

Дээд
боловсролын
салбар дахь
дижитал
шилжилтийн
тогтолцоо



Агуулга

2 Агуулга

4 Дижитал шилжилт

6 Тогтолцоо - дижитал шилжилтийг хэрэгжүүлэх бүтэц

9 Танилцуулга

10 Дижитал шилжилтийн тогтолцоо

12 Байгууллагын дижитал соёл

- 14 Дижитал соёл болон сэтгэлгээ
- 17 Байгууллагын дүр төрх
- 18 Байгууллагын сайн сайхан байдал
- 20 Байгууллагын өөрчлөлт

22 Мэдлэг бүтээх, шинийг санаачлах

- 24 Дижитал алсын хараа, чиг хандлага тодорхойлох
- 26 Судалгаа
- 28 Шинийг санаачлах
- 30 Өргөн хүрээний нөлөөлөл

32 Мэдлэг дээшлүүлэх

- 34 Сургалтын хөтөлбөр боловсруулах
- 36 Дижитал технологи ашиглан суралцах
- 38 Дижитал технологи ашиглан заах
- 40 Суралцагчийн туршлага

42 Мэдлэгийг удирдах, хэрэглэх

- 44 Мэдээллийн удирдлага, хэрэглээ
- 46 Өгөгдлийн удирдлага, хэрэглээ
- 48 Бизнесийн оюун (BI)
- 50 Шийдвэр гаргах

52 Мэдлэг солилцох, түншлэх

- 54 Харилцаа холбоо
- 55 Хамтын ажиллагаа
- 56 Олон нийтийн оролцоо
- 57 Харилцааны менежмент

58 Дижитал болон бодит дэд бүтэц

- 60 Найдвартай дижитал дэд бүтэц
- 65 Дижитал холболт
- 67 Дижитал дэмжлэг
- 68 Эд хөрөнгийн удирдлага

70 Бусад сурвалжууд, индекс

- 71 Бусад сурвалжууд
- 73 Индекс

Энэ файл нь өөр хуудас, вэб сайт руу шилжих боломжтой холбоосууд бүхий интерактив .PDF файл юм

Текст

Тайлангийн заасан хэсэг руу эсвэл вэб сайт руу шилжих холбоос



Үүндсэн диаграм руу шилжих товч (саарал бол идэвхгүй)



Мастер элементийн диаграм руу шилжих товч (саарал бол идэвхгүй)

Дижитал шилжилт

КОВИД-19 цар тахлын ажилтнууд болон оюутнуудад үзүүлсэн нөлөөллөөс гадна, эдийн засгийн хямрал, нөөц бололцооны хязгаарлагдмал байдлаас үүдэн Их Британий их сургуулиуд ихээхэн асуудалтай тулгараад байна. Дээд боловсролын салбарт үүссэн асуудал, сорилтуудыг даван туулах арга замуудын нэг нь дижитал технологид чиглэсэн стратегиудаа эргэн харах явдал юм.

Дижитал шилжилтийг амжилттай явуулахад дижитал ур чадвар бүхий ажилтнууд болон оюутнууд, оролцогч талуудын оролцоо, найдвартай дэд бүтэц, зохих ёсны хөрөнгө оруулалт, үр бүтээмжтэй дижитал манлайлал шаардагдана. Дээд боловсролын байгууллагууд (ДББ) нь нүсэр, ярвигтай бүтэц зохион байгуулалттай, өргөн цар хүрээг хамарсан үйл ажиллагаа явуулдаг тул томоохон зорилго бүхий дижитал стратегиудыг хэрэгжүүлэхэд амаргүй байдаг. Тиймээс Их Британий Хамтын мэдээллийн системүүдийн хорооноос (Хмсх буюу Joint information systems committee / Jisc) байгууллагын бүтэц зохион байгуулалтын хүрээнд өөр өөр чиг үүрэг бүхий ажлын байр, алба хэлтсүүдэд дижитал шилжилтийн үйл ажиллагааг дэмжин явуулах үүрэг хүлээсэн ахлах албан тушаалтнууд, менежерүүд болон өөрчлөлт хариуцсан ажилтнуудад зориулан энэхүү дижитал шилжилтийн тогтолцоог боловсруулан гаргалаа.

“Дижитал шилжилт нь байгууллагад боловсрол, үйл ажиллагааны шинэ загваруудыг бий болгож, бизнесийн загвар, стратегийн чиглэл, үнэ цэнд өөрчлөлт оруулах гүн гүнзгий, уялдаа холбоо бүхий соёл, ажиллах хүч, технологийг хамарсан шат дараатай шилжилтүүд юм.¹”

¹ Brown et al. Digital Transformation Signals: Is Your Institution on the Journey? Enterprise Connections (blog), EDUCAUSE Review, May 12, 2020




Тогтолцоо - дижитал шилжилтийг хэрэгжүүлэх бүтэц

Энэхүү тогтолцоо нь дижитал технологийн тусламжтайгаар багш, судлаач, оюутнуудын хийж буй зүйлээсээ эерэг туршлага хуримтлуулах, ажиллаж, сурч буй сургуулийнхаа нэг хэсэг нь болох, сайн сайхан байдлаа дээшлүүлэх асуудлуудыг цогцоор нь авч үзнэ.

Уг тогтолцоо нь инновацийг дэмжих, бизнесийн үйл явц болон үйл ажиллагааг оновчтой болгох, хамтын ажиллагааны түншлэлийг хөгжүүлэх боломжоор хангаж, стратегийн алсын харааг тодорхойлох, стратеги төлөвлөлт хийх үйл явцуудыг чиглүүлэх бүтэц бүхий байна. Багууд дан дангаараа, өөр хоорондоо хамааралгүй мэт ажилласнаас үүдэх төвөгтэй, хуваагдмал байдлыг багасгах зорилгоор хамтарсан багийн аргыг дэвшүүлэн ажиллаж, бодлого, үйл явцаа үүнд хэрхэн уялдуулахын чухлыг энд онцолсон байдаг.

Байгууллагуудад бизнесийн үйл ажиллагааныхаа бүх чиглэлээр дижитал төлөвшлийн түвшингээ үнэлэхэд туслах зорилготой, цаашид үргэлжлэн шинэчлэгдэж байх материалуудыг тус тогтолцоонд нэмэлтээр дагалдуулна. Эдгээр материалуудад Их Британийн дээд боловсролын (ДБ) салбарын хяналт, зохицуулалтын байгууллагуудаас авах боломжтой дэмжлэг туслалцаа, түүнчлэн дижитал шилжилтийг идэвхжүүлэх Хмсх-ны нөөц боломж, бүтээгдэхүүн, үйлчилгээнд чиглэсэн лавлагаа, мэдээлэл агуулагдсан байдаг.



Тус тогтолцоо нь дараахад хүрэхийг эрмэлзэнэ:

1. Салбарын хүрээнд болон дээд боловсролын байгууллагуудад дижитал шилжилтийн талаарх нийтлэг ойлголтыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

2. Үйл ажиллагааны чиглэлүүд, алба, хэлтэс, нэгжийн хооронд хуваагдал үүсгээд буй уламжлалт хил хязгаарын нийтлэг хэв шинж, тэдгээрийн холбогдсон зүй тогтолыг бүхэлд нь тодорхойлох аргачлалыг дэмжих

3. Хамтран ажиллах аргачлалыг дэмжиж, салбарын болон байгууллагуудын хуримтлуулсан хамтын мэдлэг, туршлагын нөөц бололцоон дээр дөрөөлөн сайжруулж явах

4. Төвөгтэй, нүсэр байдлаас зайлсхийж, хоорондоо уялдаа холбоогүй, хуваагдмал процессуудыг багасгахад туслах
5. Дижитал шилжилтийн стратегийн алсын харааг тодорхойлж, түүнд хүрэхийн тулд хэрэгжүүлэх боломжтой төлөвлөгөө боловсруулахад дээд боловсролын байгууллагуудыг дэмжих.

6. Мэдээлэл, дүн шинжилгээнд суурилсан шийдвэр гаргах, хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх

7. Зөвхөн үйл явц, технологид төдийгүй хүмүүс болон арга барилд анхаарлаа хандуулах

8. Манлайлал болон дижитал чадавхыг амжилтын чухал хүчин зүйл болгон онцгойлох

Уг тогтолцоог дагалдах материалуудын хамт дараах зорилгоор байгууллагын хэмжээнд ашиглах боломжтой:

- Үйл ажиллагаа, давуу тал, томоохон зорилтууд, түүнчлэн стратегийн гол зарчмууд болон үнэт зүйлсийг тодорхойлон дүрслэх
 - Гол оролцогч талуудыг цуглуулан үүрэг, хариуцлагыг хуваарилах, мөн байгууллагын аль үйл ажиллагааг ямар баг хариуцан явуулах мэдлэг, чадвартай болохыг тодорхойлох.
 - Байгууллагын дижитал мэдлэг, чадварын дотоод нөөц, бололцоог нээн илрүүлж, үүнийг байгууллагын алба, хэлтэс, нэгж хоорондын зааг, хязгаарыг бууруулахад илүү үр дүнтэй ашиглахаар төлөвлөх.
 - Мэдлэг чадвар дутуу, үүрэг хариуцлага хангалтгүй зэрэг аливаа алдаа дутагдлыг олж илрүүлэн, засаж сайжруулах
 - Үйл ажиллагааны чиглэлүүдээр дижитал төлөвшлийн түвшинг тодорхойлох: шинээр үүссэн, тогтворжсон, сайжруулсан (хөгжлийн үе шатандаа)

- Дижитал стратеги/иудын хөгжил, амжилтыг дэмжиж, стратегиудыг хооронд нь холбож өгөх
 - Хүрэх боломжтой, хэмжиж болохуйц үйл ажиллагааны буюу арга хэмжээний төлөвлөгөө гаргах
 - Хуучин, хоцрогдсон систем, аргачлалаас шилжин урагшлах

- Байгууллага бүрийн гарааны байр суурь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой, төлөвшлийн түвшин нь ялгаатай учир нөхцөл байдалдаа тохируулан одоогийн байр суурь болон дараагийн алхмуудыг тодорхойлох.

Танилцуулга

Тойм

Дараахыг оролцуулаад Их Британийн мэргэжлийн олон байгууллагын санал, зөвлөмжийг тусгасны үндсэн дээр энэхүү тогтолцоог боловсруулсан болно: [Адванс Эйч-Ий \(Advance HE\)](#), [Сургалтын технологийн холбоо \(Association for Learning Technology / ALT\)](#), [Их сургуулийн администраторуудын холбоо \(Association of University Administrators / AUA\)](#), [Их сургуулийн эд хөрөнгө хариуцсан захирлуудын холбоо \(Association of University Directors of Estates / AUDE\)](#), [Дээд боловсролын чанарын баталгаа хариуцсан агентлаг \(Quality Assurance Agency for Higher Education / QAA\)](#), [Коллежийн, үндэсний болон их сургуулийн номын сангуудын нийгэмлэг \(Society of College, National and University Libraries / SCONUL\)](#), [Их сургууль болон коллежийн мэдээллийн системийн холбоо \(Universities and Colleges Information Systems Association / UCISA\)](#), [Их Британий их сургуулиуд \(Universities UK / UUK\)](#) болон [Вийтай ашгийн бус хөтөлбөр \(Vitae\)](#). Ингэснээр уг тогтолцоонд салбарын нэн чухал асуудлууд тусгагдаж өгсөн бөгөөд мөн үүнийг Их Британид одоо ашиглагдаж буй дээд боловсролын гол гол загварууд болон тогтолцоонуудтай нийцүүлэн уялдуулж өгсөн юм. Анх 2015 онд гаргаад 2018 онд дижитал шилжилтийг түлхүү анхаарч тусгах зорилгоор шинэчилсэн [Хмсх-ны байгууллагын дижитал чадамжийн тогтолцоо](#) болон дижитал төлөвшлийн загвар дээр суурилан энэхүү тогтолцоог боловсрууллаа.

Уг тогтолцоогоор мэдлэгийг байнгын хэрэглээ болгох аргачлалыг сонгон хэрэгжүүлсэн. Байгууллагын суурь дижитал дэд бүтэц болон бодит дэд бүтэц, дижитал соёл зэргээс гадна дээд боловсролын байгууллагын төрөл бүрийн үйл ажиллагаа, туршлага, дадал хэвшлүүд дээр мэдлэгийн дөрвөн үндсэн практик дадал төвлөрдөг.

- Мэдлэг бүтээх, шинийг санаачлах
- Мэдлэг дээшлүүлэх
- Мэдлэгийг удирдах, хэрэглэх
- Мэдлэг солилцох, түншлэх

Энэ нь технологийн болон бизнесийн үйл явцад суурилсан арга барилд ач холбогдол өгөхөө больж, дээрх дөрвөн дадлыг байгууллага дотроо сайжруулахад хүмүүс юу хийдэг эсвэл хийх ёстой вэ гэдэг дээр анхаарлаа хандуулна гэсэн үг юм.

Энэхүү аргачлал нь мөн байгууллагуудад уламжлалт хил хязгаараа даван бүх нэгж болон түвшин хоорондын харилцаа, хамаарал, хамтын ажиллагааны боломжуудыг олж харахад нь тусалж, бүх оролцогч талуудыг идэвх зүтгэлтэй, тууштай байхыг дэмжинэ.

Дижитал шилжилтийн зарим чухал тал, амжилтын хүчин зүйлүүд тогтолцоог бүхэлд нь хамарч нөлөөллөө үзүүлдгийг энд онцлох нь зүйтэй. Эдгээрийг дурдвал: манлайлал, стратегийн алсын хараа, зохистой хөрөнгө оруулалт, тэгш байдал, ялгаатай байдал ба тэгш хүртээмж, тогтвортой байдал, оролцогч талуудын оролцоо, аюулгүй байдал ба аюулгүй ажиллагаа, олон улсын үйл ажиллагаа, ажилтнуудын сургалт болон хөгжил, дижитал сайн сайхан байдал зэрэг юм. Дээрх бүгд хэдийгээр тогтолцооны олон үе шатыг хамрах боловч тодорхой хүрээний ажилтнууд буюу бусад оролцогч талуудын ажил үүрэг, ажиллах чиглэлтэй холбоотойгоор хэрэгждэг. Дижитал шилжилтийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг бүрт эдгээр ерөнхий хүчин зүйлс болон талуудыг онцолсон, мөн байгууллагын стратегийн гол зарчмууд, үнэт зүйлсийг тусгасан түлхүүр үгсийг жагсаан оруулсан байна.

Энэхүү тогтолцооны бүтцийн хамрах хүрээнд өнөөг хүртэл хуримтлуулсан хамтын мэдлэг, ухаан дээрээ тулгуурлан урагшлах болон мэдээлэл, өгөгдлийг ухаалгаар ашиглахын ач холбогдлыг, мөн нийгмийн болон сургалтын сүлжээгээр дамжуулан дэлхийн хэмжээнд мэдлэг бүтээх, солилцох, шинийг санаачлахын үр нөлөөг онцлон тэмдэглэдэг.

Уг тогтолцоогоор дамжуулан дижитал шилжилтийн үйл ажиллагааны элементүүдийг хүрч болохуйц зорилго, үйлдэл болгох хуваах боломжтой. Тогтолцоонд хамаарах мэдээллийг өргөн хүрээ хамарсан ерөнхий тайлбар, мэдэгдлээс авахуулаад тодорхой үйл ажиллагааг нарийн дүрсэлсэн жишээ хүртэл олон янзын түвшинтэйгээр толилуулна. "Оролцогч талууд" гэсэн нэр томъёог тогтолцооны хэмжээнд ашиглахдаа хамгийн өргөн хүрээг хамрах утгаар нь буюу ахлах удирдагч, удирдах ажилтан, ажилтан, одоо суралцаж буй оюутан, төгсөгч, түүнчлэн ажил олгогч, бизнесийн консорциумын гишүүн зэрэг бусад түншүүдийг оруулсан утгаар ойлгоно.

Дижитал шилжилтийн тогтолцоо

Дижитал шилжилтийн тогтолцооны зургаан элемент, үйл ажиллагааны дөрвөн гол чиглэл






Байгууллагын дижитал соёл

Дижитал технологи ашиглаж эхэлсний нөлөөгөөр хувьсан өөрчлөгдөх байгууллагын үнэт зүйлс, итгэл үнэмшил, арга барил. Байгууллагын үндсэн стратеги, захиргааны бүтэц болон үйл явц, үр дүнтэй засаглал, оролцогч талуудын дэмжлэг, хөгжил, оролцоонд анхаарсан дижитал соёл болон манлайллыг (стратеги, төлөвлөлт, хөрөнгө оруулалт) дэмжин чадавхжуулах.

Мөн дижитал аюулгүй байдал, дижитал сайн сайхан байдал, нээлттэй байдал, хамтын ажиллагаа, тэгш байдал, олон талт байдал, тэгш оролцоо зэрэг асуудалд хандах байгууллагын хандлагыг тодорхойлох, түүнчлэн өөрчлөлтийг хэр сайн хэрэгжүүлж, түүнд дасан зохицохыг тодорхойлох хүчин зүйл нь байгууллагын дижитал соёл юм.





Дижитал соёл болон сэтгэлгээ

Дижитал соёл болон сэтгэлгээ гэх ойлголтод хүмүүсийн дижитал технологитой харилцах харилцааг хэлбэржүүлдэг хандлага, зан төлөв, итгэл үнэмшил, дадал хэвшил гэх хүний хүчин зүйлүүдийг, мөн эдгээрийн байгууллагын үйл ажиллагааг хувирган өөрчлөх арга замуудыг хамруулан авч үзнэ. Түүнчлэн шинийг санаачлах, хамтран ажиллах, мэдээлэл солилцох, дижитал контент бүтээх болон ашиглах үйл явцуудад хандах оролцогч талуудын хандлага, эдгээр үйл явц нь хэрхэн оролцогч талуудын ажиллах, суралцах нөхцөлийг сайжруулж болох талаар авч үзнэ.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөлт | Дижитал манлайлал | Дижитал ядуурал | Дижитал стратеги | Ирээдүйн хувилбарт таамаг | Засаглал | Байгууллагын үнэт зүйлс

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлстэй нийцсэн дотоод дижитал соёлыг хөгжүүлж, загварчлах; бусдын нэр төрийг эрхэмлэх, бусдад эелдэг, хүндэтгэлтэй хандах хандлагыг дэмжих.

Байгууллагын дижитал соёл нь тэгш байдал, олон талт байдал, тэгш оролцоог дэмждэг байх.

Үйл ажиллагааны жишээ

- Байгууллагын зарчим, үнэт зүйлсийг тусгасан, хоорондоо зөвшилцөн тохирсон нэр томъёоны тайлбар тодорхойлолт бүхий тайлбар толь гаргах зорилгоор оролцогч талуудтай хамтран ажиллах (жишээ нь: тэсвэрлэн сэргэх чадавх, тогтвортой байдал, тэгш оролцоо, төгсөгчдийн ур чадвар, хариуцлагатай, ёс зүйтэй судалгаа, инноваци)
- Байгууллагын үйл ажиллагааны чиглэл бүрээр буюу алба, хэлтэс, нэгжүүдэд баримтлах дижитал арга барил, зан үйл, дадал хэвшил болон эдгээртэй холбоотой ойлголтуудыг тодорхой, цэгцтэй томъёолсон ажлын байрны зан үйлийн дүрмийг боловсруулах
- Ажлын арга барилаа сайжруулах, зохих журмаар батлуулан саналаа дэвшүүлэх шинэ дижитал боломжуудыг эрэлхийлэхэд нь ажилчдаа хөхүүлэн дэмжих
- Ажилтнууд болон суралцагчид автоматжуулсан мэдэгдэл буюу сонордуулга ашиглахдаа зөвшөөрөл өгдөг байх нөхцөлийг хангах ёс зүйн тогтолцоог хэрэгжүүлэх

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Дижитал чадавх | Дижитал итгэлтэй байдал | Дижитал цогц чадвар | Дижитал инновац | Дижитал манлайлал | Хүний нөөц | Оролцогч талуудын оролцоо

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Хувьсал, өөрчлөлтийг дэмжин нэвтрүүлэх зорилгоор дижитал технологийг чөлөөтэй ашигладаг байх соёлыг хэвшүүлэх.

Байгууллагын хувьд дижитал чадавх гэж юу болох талаар нийтлэг ойлголтыг бий болгох; байгууллагын хэмжээнд оролцогч талуудыг хамруулж, татан оролцуулах

Байгууллагын дижитал чадавхын төлөвлөгөө боловсруулах. Оролцогч талуудын итгэлийн түвшинг шалгах; дижитал суралцах чадавх, одоогийн болон шинэ ажлын байранд шаардагдах чадавхыг тодорхойлох; сургалт болон дэмжлэг үзүүлэх механизмыг боловсруулах.

Үйл ажиллагааны жишээ

- Одоо байгаа ажлын байрны тодорхойлолт, хувь хүний чадварыг эргэн харж, ажлын байр тус бүрт шаардагдах дижитал чадавхыг шинэчилсэн байх шаардлагатай
- Ажилтнууд болон оюутнууддаа өөрсдийн дижитал чадавхыг үнэлэх, эрэгцүүлэх, мөн чухал гэж үзсэн чиглэлийн чадваруудаа сайжруулах хувь хүний хөгжлийн төлөвлөгөө боловсруулах боломжоор хангах
- Дижитал манлайлагчдыг өөрсдийн дижитал чадавхаа үнэлж, эргэцүүлэх, мөн дижитал чадавхаа сайжруулж дижитал итгэлтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бусдад үлгэр дууриалал үзүүлэх боломжоор хангах.
- Ахлах удирдагчдад дижитал манлайллын сургалтанд хамрагдах боломжийг олгох
- Өөр өөр бүлгүүдийн (дижитал удирдагч, мэргэжлийн үйлчилгээ, багш, оюутан, номын сангийн ажилтан, сургалтын технологич, судлаач гэх мэт) дижитал чадавхыг харгалзан үзэж, суурь дижитал чадавхыг тодорхойлох зорилгоор Хмсх-ны ажлын байрны ур чадварын тодорхойлолтуудыг ашиглах

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Дижитал инновац | Дижитал манлайлал

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Шинийг санаачлах, туршиж үздэг байх соёлыг бий болгож, дэмжих
Шинээр систем, үйл ажиллагаа, үйлчилгээ бий болгон, хөгжүүлэхдээ "Digital by Design"
буюу "дижитал дизайнтай" байх аргачлалыг хэрэгжүүлэх

"Нэгдүгээрт дижитал" буюу дижитал төвт аргачлалыг хөгжүүлж, хэвшсэн уламжлалт арга
барилаа илүүд үзэх хандлагаа засахыг зорих (уламжлалт дижитал бус аргачлалыг
заавал солих албагүй).

Үйл ажиллагааны жишээ

- Байгууллага даяар ашиглагдаж буй дижитал болон дижитал бус бүх харилцах системд аудит хийж харилцан уялдаа холбоо, нэгдсэн нэг эх сурвалж бүхий хэрэглэгчтэй харилцах систем (Customer Relationship Management system буюу CRM) систем хөгжүүлэх



Байгууллагын дүр төрх

Байгууллагын дүр төрх гэдэг нь байгууллагыг тодорхойлж, бусдаас ялган харуулдаг өвөрмөц онцлог, чанарууд юм. Байгууллагын стратегийн зарчим, үнэт зүйлсийг таниулан, сурталчлахыг дэмжих дижитал үйл ажиллагаануудыг, мөн эдгээр нь хэрхэн бизнесийн арга барилд тусгалаа олж, оролцогч талуудад нөлөөлөх талаар авч үзнэ.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Дижитал бүлэг байгуулах | Бизнес ба үйлдвэрлэл | Олон улсын үйл ажиллагаа | Маркетинг ба харилцаа холбоо | Харьяалагдах хэрэгцээ

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Байгууллагыг гадаад ертөнцөд таниулах, эрхэм зорилго, үнэт зүйлсийг тусгасан дижитал дүр төрхийг илтгэх бүртгэл үүсгэн ашиглах.
Ажилтан болон оюутан бүрийг онлайн бүртгэл үүсгэж, хувийн болон байгууллагын ашиг сонирхолд нийцүүлэн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

Ажилтнууд болон оюутнуудын онлайн орчинд гаргасан сөрөг зан үйлийн эрсдэлээс байгууллагыг хамгаалах шаардлагатай.

Дижитал хэрэгсэл болон сүлжээ ашиглан хүртээмж, тэгш оролцоо, тэгш боломжийг нэмэгдүүлэх нөхцөлийг хангаж, улмаар дижитал хэлбэрээр оролцох, хамрагдах явдлыг байгууллага даяар дэмжих.

Олон улсын үйл ажиллагаа, санаачилгууд нь байгууллагын олон нийтэд танигдах дүр төрхөд хэрхэн нөлөөлж буйг авч үзэн, уялдаа холбоотой стратегийг байгууллагын үйл ажиллагааны бүх чиглэлээр нэвтрүүлэх. Олон улсын үйл ажиллагааг байгууллагын бүх стратегид тусган оруулах.

Үйл ажиллагааны жишээ

- Бүх оролцогч талуудад харьяалагдах хэрэгцээ буюу хамт олон, хүрээллийнхээ нэг хэсэг нь байх мэдрэмж, хэрэгцээг таниулан, ухуулах, мөн тэдэнд ирц, оролцоогоо бодитоор болон онлайнгаар, буюу холимог байдлаар баталгаажуулах боломж олгох
- Оюутнуудыг суралцах хугацааныхаа туршид мэргэжил/карьертайгаа холбоотойгоор өөрийн гэсэн дижитал бүртгэл, орон зай бий болгож, хөгжүүлэхийг уриалах





Байгууллагын сайн сайхан байдал

Бүх оролцогч талуудын бие бялдар, сэтгэл санааны болон сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хангах, дэмжих, сайжруулах. Дижитал технологиор дамжуулан ажиллаж, амьдарч, суралцах, түүнчлэн хувь хүний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг сайжруулж, удирдахад дижитал аргачлал нэвтрүүлэх зэрэгт үзүүлэх нөлөөллийг оруулан авч үзнэ.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Тэгш хүртээмж ба тэгш оролцоо | Кибер аюулгүй байдал | Дижитал цогц чадвар | Дижитал сайн сайхан байдал | Эдийн засгийн/Санхүүгийн мэдлэг | Хөдөлмөрийн харилцаа | Байгаль орчны тогтвортой байдал | Уян хатан ажлын байр | Хүний нөөц | Ажилд авах, ажилд үлдээх | Ажилтанд үзүүлэх дэмжлэг

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Дижитал төхөөрөмжийн эрүүл мэндэд үүсгэх нөлөөллийн талаар тусган оруулсан, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих дижитал хэрэгсэл, үйлчилгээг санал болгон оруулсан байгууллагын сайн сайхан байдлын бодлогыг боловсруулж, удирдах.

Байгууллагын холбогдох стратеги, бодлогуудад эрүүл мэнд, сайн сайхан байдлыг тусган оруулах.

Байгууллагын хэмжээнд дижитал технологи ашиглах эрүүл, тогтвортой арга барилыг үлгэр жишээ болгон, дэмжих.

Байгууллагын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны бодлогуудыг шинэчилж, дижитал асуудлуудыг тусган оруулсан байх; хөдөлмөрийн эрүүл ахуйн практикт дижитал арга, хэрэгслийг үр дүнтэй ашигладаг байх.

Онлайн зан үйлийн хууль эрх зүй, ёс зүй, аюулгүй байдлын талаар ажилтнууд болон оюутнуудад зориулсан бодлого боловсруулах.

Онлайн хүчирхийлэл, кибер дээрэлхэлт, кибер луйврын талаар байгууллагын хэмжээнд аргачлал боловсруулж, хянах.

Дижитал боломж, эрсдлүүдийн талаар бодитоор ойлгож мэддэг байх, үүн дээр тулгуурлан эрүүл, дижитал ажлын байр бий болгох.

Бүх оролцогч талуудын өөр өөр хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцүүлэн ажиллаж, суралцах уян хатан аргачлалыг хэрэгжүүлэх.

Үйл ажиллагааны жишээ

Бүх оролцогч талуудыг хамруулан, оролцуулж, дижитал харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан хэлэлцэн зөвшилцөх, соёлтой мэтгэлцэх, үзэл бодлын зөрүүг хүлээн зөвшөөрч хүндэтгэсэн байдлаар харилцахад зориулсан нэгдсэн удирдамж, аргачлалыг боловсруулах

Бүх оролцогч талуудыг ажиллаж, суралцах адил, тэгш нөхцөлөөр хангах

- зорилгоор хүртээмжтэй байдал, тэгш оролцоог сайтар тусгасан бодлого, удирдамжуудыг боловсруулан, арга барил нэвтрүүлж, дэмжлэг үзүүлэх

- Хүртээмжтэй байдал, тэгш оролцоо, сайн сайхан байдалд тулгарсан сорилт, асуудлуудыг нэн тэргүүнд шийдвэрлэхэд анхаарах

Ажилчдыг эрүүл мэнд, сайн сайхан байдлаа (жишээ нь: цагийн менежмент, ажлын ачаалал эрэмбэлэх, дэлгэцийн цаг) хянан, зохицуулах дижитал хэрэгсэл, програм эсвэл үйлчилгээгээр хангах, эдгээрийг ашиглахыг дэмжих

- Ажилтнууд ба/буюу оюутнуудын эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хянах дижитал сонордуулгыг (автоматжуулсан мэдэгдэл) ёс зүйтэй ашиглах үндэслэлийг судлах

Чадварлаг ажилтныг ажилд авах, ажлын байранд тогтоон барих асуудлыг сайжруулах зорилгоор зохих зарим албан тушаалд алсын зайнаас / холимог байдлаар ажиллахыг санал болгох. Оролцоог хөхүүлэн дэмжих; ажлын даалгавар, арга хэмжээ, үйл явдлыг дижитал хэлбэрээр явуулахаар болгож өөрчлөн тохируулах; сэтгэцийн эрүүл мэнд, эрх тэгш байдлын асуудлыг анхаарч шийдвэрлэх

- Уян хатан, холимог ажлын соёлыг дэмжихийн тулд ажлын орон зай, оффисийг шинэчлэх буюу сайжруулан тоноглох (жишээ нь, сайжруулан тоноглогсон анги, хурлын өрөө, дундын оффис)





Байгууллагын өөрчлөлт

Дижитал шилжилтийн үйл ажиллагааны үр нөлөөг урьдчилан таамаглах, удирдах, хариу арга хэмжээ авах. Төлөвлөсөн санаачлагууд, үйл ажиллагаадаар дамжуулан оролцогч талуудыг арга барил, хүлээлт шаардлага, хандлагаа өөрчлөхөд нь дэмжиж туслах.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Суурь түвшин тогтоох | Байгууллагын стратеги | Дижитал инновац | Дижитал манлайлал | Дижитал стратеги | Урьдчилан харах | Засаглал | Хөрөнгө оруулалт | Үйл ажиллагааны өөрчлөлт

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Их сургуулийг удирдан чиглүүлэгчид нь дижитал, өгөгдөл, технологи зэрэг ойлголтын шилжилт өөрчлөлт авчрах мөн чанарыг, эдгээрийн оюутнууд болон ажилтнуудад үзүүлэх эерэг нөлөөллийг бүрэн ойлгосон байх.

Дижитал шилжилтийн стратеги, санаачлагыг боловсруулж, удирдан чиглүүлэх; нэгдсэн дижитал аргачлалын хүрээнд үр дүн өгөх үйл ажиллагаа, үйлчилгээ, арга барил, системүүдийг тодорхойлох.

Дижитал шилжилт буюу өөрчлөлтийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөл боловсруулж, удирдах; оролцогч талуудыг татан оролцуулах; хамтын ойлголтыг хөгжүүлж, хүрч болох зорилтууд тогтоох; байгууллага даяар хоорондоо хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж, удирдлагаар хангах.

Инновацыг урамшуулж, эрсдэлийг хүлээн зөвшөөрөх соёлыг бүрдүүлж, ажилтнуудыг дэмжиж, шинэлэг аргачлалыг үлгэр жишээ болгох замаар дижитал өөрчлөлтийг амжилттай явуулах бүтээлч арга хэмжээ авах.

Нөхцөл байдалд дасан зохицож, хариу арга хэмжээ авах чадвартай ажиллах хүчин бүрдүүлэх, инновацын agile буюу хурдтай аргыг хэрэгжүүлэх, эрсдэлийг урьдчилан тооцоолж хянах соёлыг бий болгож удирдан чиглүүлэх.

Хөдөлмөрийн зах зээл тогтворгүй, хурдацтай өөрчлөгдөж буй үед урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор дижитал ур чадвартай ахлах удирдагчдыг ажилд авах, тогтвортой ажиллуулах стратеги боловсруулах.

Үйл ажиллагааны жишээ


- Ахлах удирдагчид нь дижитал манлайлагчийн ажил үүргээ тодорхой ойлгосон, дижитал технологийн сайн туршлага, шинэлэг хандлагыг бусдад үлгэрлэн үзүүлэх итгэл төгөлдөр байх шаардлагатай
- Хөгжлийн төлөвлөгөөнүүдтэй холбогдуулан одоо байгаа дээд шатны удирдлагын бүлэг / хороодын хариуцлага, эрх үүрэгт дүн шинжилгээ хийж, энэ хүрээнд аливаа тодорхойгүй, ойлгомжгүй үлдсэн зүйлс байгаа эсэхийг илрүүлэх, бүлгийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох
- Ажилтнуудад дижитал шилжилтээс үр ашиг хүртэх цаг хугацаа, орон зайн нөхцөлийг бүрдүүлж өгөх, сайн туршлагыг сайшаан, хуваалцах






Мэдлэг бүтээх, шинийг санаачлах

Байгууллагын үйл ажиллагааны бүх чиглэлд шинээр гарч ирж буй чиг хандлага, хөгжил дэвшлийн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр бодлого, хөгжлийн стратеги боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангах. Судалгаа шинжилгээ хийх, хамтын ажиллагаа явуулах замаар мэдлэг бүтээх, шинийг санаачлах үйл явцыг нэмэгдүүлэх. Орон нутгийн, бүс нутгийн, үндэсний болон олон улсын хэмжээний өргөн хүрээнд үзүүлэх нөлөөллийг харгалзан авч үзэх





Дижитал алсын хараа, чиг хандлага тодорхойлох

Салбарын болоод байгууллагын тэргүүлэх чиглэл, үйл ажиллагаанд одоогийн болон ирээдүйн дижитал чиг хандлагын үзүүлэх нөлөөллийг урьдчилан харж, бэлтгэх.

Стратеги төлөвлөлт, шийдвэр гаргах үйл явцыг шаардлагатай мэдээллээр хангах зорилгоор дээд шатны удирдах ажилтнуудад ирээдүйг урьдчилан таамаглахад шаардагдах мэдээлэл цуглуулах, олж авах боломжоор хангах.

Чиглэл / зарчим/ үнэт зүйл

Бенчмаркинг буюу харьцуулсан жишиг тогтоох | Дижитал бүтээлч байдал | Дижитал манлайлал | Дижитал алсын хараа | Урьдчилан харах | Ирээдүйн хувилбарт таамаг | Чиг хандлага тодорхойлох | Олон улсын үйл ажиллагаа | Аж үйлдвэрлэлийн чиг хандлага | Стратеги төлөвлөлт | Салбарын чиг хандлага

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Дээд шатны удирдах ажилтнуудад "ирээдүйг хувилбар дэвшүүлэн таамаглах" сэтгэлгээг бий болгох.

Аж үйлдвэр, салбарын чиг хандлагыг судалж, шилдэг гүйцэтгэлийн харьцуулсан жишиг тогтоох (жишээ нь, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт) зорилгоор холбогдох оролцогч талууд, удирдах ажилтнуудаас тогтсон бүлгүүд үүсгэн ажиллах.

Технологи болон дээд боловсролд нөлөөлж буй чиг хандлагуудыг системтэй судлах замаар байж болох боломжууд, болзошгүй аюул заналхийлэлд бэлтгэх.

Ирээдүйг төлөвлөхөд чухал нөлөөтэй, үр дүнтэй асуулт асуух, оролцогч талуудаас баримт материал цуглуулах аргачлалууд боловсруулах боломж нөхцөлийг дээд шатны удирдах ажилтнуудад бүрдүүлж өгөх.

Байгууллага даяар дижитал бүтээлч байдлын соёлыг төлөвшүүлэх.

Өнөөгийн хөгжил болон ирээдүйн боломжуудын талаар мэдлэгтэй байх, дэлхийн бусад улс орон, байгууллагуудаас суралцах нөхцөлийг байгууллагадаа бүрдүүлэх зорилгоор чиг хандлага тодорхойлох олон улсын аргачлалыг нэвтрүүлэх.

Үйл ажиллагааны жишээ

- Дээд шатны удирдах ажилтнуудад зориулсан чиг хандлага, хэтийн төлөв тодорхойлох цуврал семинар зохион байгуулах
- Удирдах ажилтнуудыг аж үйлдвэр, судалгаа хөгжил, боловсрол, бизнесийн салбар дахь дижитал шилжилтийн талаар мэддэг байхад, мөн тохирох шинэ туршлага, арга барилыг (жишээлбэл, сургалтын хөтөлбөр боловсруулах, мэдлэгийн практик дадал) байгууллагад хэрхэн нэвтрүүлэх талаар анхаарч үзэхэд дэмжих
- Байгууллагад бодлогын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, ирээдүйг хувилбар дэвшүүлэн таамаглах буюу урьдчилан харах тогтолцоог бий болгох





Судалгаа

Судалгаа шинжилгээний ажлыг дэмжин тогтвортой дэд бүтцээр хангах. Үүнд, стратегийн аргачлалууд боловсруулах, дижитал систем, орчин, процесс, технологид зохих хөрөнгө оруулалт хийх, судлаачдыг татах, идэвхжүүлэх, хөгжүүлэх, дэмжих зэрэг орно.

Чиглэл / зарчим/ үнэт зүйл

Дижитал бүлэг үүсгэх | Дижитал стратеги | Ёс зүй | Олон улсын үйл ажиллагаа | Номын сан, сургалтын нөөц | Нээлттэй судалгаа | Судалгааны хамтын ажиллагаа | Судалгааны удирдлага, дэмжлэг | Судалгааны ур чадварыг дээшлүүлэх, сургалтанд хамруулах | Судалгаанд дэмжлэг үзүүлэх

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Дижитал судалгааны дэд бүтэц, судалгааны хөрөнгийн удирдлага, нээлттэй судалгаа / нийтлэл, мэдлэг солилцоо, түншүүдтэй олон улсын гм чиглэлээр хөгжүүлэх хамтын ажиллагаа, итгэмжит найдвартай судалгаа, судалгааны өгөгдлийн удирдлага, дижитал судалгааны соёлд зориулсан бодлого, зохицуулалтуудыг оруулаад дижитал судалгааны стратегиуд эсвэл тэдгээртэй адилтгах бодлого, стратегиудыг боловсруулах.

Судалгааны хөгжлийн циклийн үе шат бүрт тууштай, чамбай, шалгарсан арга барил хэрэгжүүлэн баримталж, судалгааг ёс зүйтэй, хариуцлагатай, шударга, найдвартай, дахин давтагдах боломжтой, ил тод, нээлттэй, аюулгүй орчинд явуулахад анхаарч ажиллах.

Дижитал судалгааны орчин болон системүүд, мөн түүнчлэн ахисан түвшний дижитал судалгаанд зориулагдсан дэд бүтцэд хөрөнгө оруулах. Судалгаа хийхэд зориулж тогтвортой биет болон дижитал дэд бүтцийг бүрдүүлэх - (зардлыг оновчилсон програм хангамж, технологи, дэд бүтэц (дэд бүтцийн хэсгээс үзэж болно)).

Судлаачдын хөгжлийг дэмжих таатай орчныг бүрдүүлж, дижитал судалгааны ур чадварыг сургалтын хөтөлбөр, судлаач болон ажилтнуудын хөгжлийн хөтөлбөрт оруулсан байх.

Судлаачдыг ажилд авах, хөгжүүлэх, ажилд нь тогтоон барих боломжийг бүрдүүлэх.

Судалгааны удирдлага, мэдээллийн технологийн дэмжлэг, судалгааны ур чадвар зэрэг чиглэлээр судлаачдад шаардлагатай мэргэжлийн дэмжлэг үзүүлэх.


Олон улсын хөрөнгө оруулалт, ажилтнуудын шилжилт хөдөлгөөн болон зохих олон улсын бодлого, зохицуулалт, дэд бүтцийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын судалгааны хамтын ажиллагааны шинэ боломжуудыг тодорхойлох.

Эрх тэгш, олон янз байдал, тэгш оролцоог эрхэмлэсэн дижитал судалгааны соёлыг хөгжүүлж, дэмжих.

Үйл ажиллагааны жишээ

- Дижитал хэлбэрээр холбогдсон бүлгүүдээр дамжуулан олон өөр салбар хамтарсан буюу салбар дундын судалгаа хийх аргачлалыг идэвхжүүлэх
- Судалгааны ажлын цар хүрээ, төрөлд тохирсон дэд бүтэц, материаллаг баазаар хангах
 - Төвөгшил өндөртэй/өндөр хүчин чадал шаардах судалгааны ажлыг дэмжин явуулах
- зорилгоор байгууллага доторх болон гаднах шаардлагатай технологиудад (жишээ нь, өндөр гүйцэтгэл шаардах тооцоолол) хандан ашиглах арга замыг тодорхойлох
- Судалгааны өгөгдлийг зохих шаардлага хангасан, найдвартай, хяналт зохицуулалт сайн орчин, нөхцөл бүрдүүлж хадгалахад анхаарах
 - Нээлттэй судалгааны өгөгдлийг удирдах дэд бүтэц буюу систем, програм, сүлжээ, сервер зэрэгт аюулгүй хандан ашиглах боломжоор хангах, мөн хадгалалт, устгал зэргийг оруулаад судалгааны өгөгдлийн амьдралын циклийн бүхий л үе шатуудыг тодорхой заан оруулсан бодлого боловсруулах
- Дотоод болон гадаад дижитал сан гм судалгааны үр дүн болон байгууллагын баримт материалыг хадгалах, хайх, татах зэрэгт зориулагдсан үр дүнтэй агуулга удирдах системүүдийг хөгжүүлж, ашиглаж, хэвийн ажиллагааг хангах
- Судалгаа шинжилгээний материаллаг хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор судалгаа шинжилгээнд ашиглагдах биет хөрөнгө, тоног төхөөрөмжийг дижитал хэлбэрээр удирдах замыг тодорхойлох
- Судлаачдыг шаардлагатай нөхцөлд судалгааны програм хангамж, өгөгдлийн инженерчлэлийн үйлчилгээнд хамруулах арга замыг тодорхойлох
- Тодорхой зарим судалгааны төслүүдийн кодыг хөгжүүлж, сайжруулахад зориулж судалгааны програм хангамжийн инженерчлэлийн үйлчилгээг судлаачдад санал болгох
- Судалгааны удирдлагын процессуудыг хялбаршуулан, энгийн болгох замаар судлаачдад учирдаг хүнд суртал, захиргааны дарамтыг бууруулах
- Үр дүнтэй, харилцан уялдаж ажиллах боломжтой судалгааны удирдлагын системүүд, процессууд, технологийг удирдан хянаж, ашиглалтын бэлэн байдлыг хангах





Шинийг санаачлах

Бүтээлч байдал, бизнес сэтгэлгээ, дижитал манлайллыг уриалан дэмжих замаар шинэ санаа, шийдлүүдийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Тохирох буюу шаардлага хангасан инновацыг стратегийн зорилго, алсын хараа, одоо ашиглагдаж буй арга барил, хуучны системүүд болон процессуудтай уялдуулах.

Чиглэл / зарчим/ үнэт зүйл

Олон нийтийн хамтын ажиллагаа | Дижитал бүтээлч байдал | Дижитал манлайлал | Дижитал стратеги

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Стратегийн зорилгууддаа нийцүүлэн дижитал инновацын төслүүдийг хэрэгжүүлэх.

Байгууллага даяар дижитал систем, хэрэгсэл, үйлчилгээ бий болгон, ашиглах шинэлэг аргачлал боловсруулж, удирдан чиглүүлэх.

Шинэлэг арга туршлагыг үлгэрлэн харуулах, байгууллагын стратегид нийцсэн инновацын соёлыг хөгжүүлэхэд нь байгууллагын удирдах ажилтнуудад дэмжлэг үзүүлэх.

Байгууллага даяар шинийг санаачлах арга барилд тулгарч буй саад бэрхшээлийг (жишээ нь: хоцрогдсон технологи ашиглах гм дэд бүтцийн, урамшуулал болон мэргэжлийн хувьд өсөж дэвшихтэй холбоотой бүтэц зохион байгуулалтын, цагийн менежмент болон ажлын даалгаврыг удирдан зохицуулахтай холбоотой асуудлууд) тодорхойлж, эерэг хариу арга хэмжээ авах

Бүх түвшний ажилтнуудын дунд инновацыг хүлээн зөвшөөрч, сайшаан үнэлдэг байх.

Дижитал хэлбэрээр ажиллах арга барил дээр суурилан байгууллагын бүтэц зохион байгуулалтад инновац нэвтрүүлэх.

Байгууллагын зүгээс орон нутгийн иргэд, бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллаж, орон нутаг болоод бүс нутгийг сайжруулах санаачлагад хувь нэмрээ оруулахын төлөө бусадтай хамтран ажиллах боломжтой салбаруудыг тодорхойлох.

Үйл ажиллагааны жишээ

- Мэргэжлийн ажлын байранд бүтээлч дижитал мэргэжилтнүүдийг олж сонгох, ажилд авах, хөгжүүлэх, тогтвортой ажиллуулах боломжийг бүрдүүлэх
- Урьдчилан тооцоолсон эрсдэлийг хүлээн, шинэ буюу өөр технологиудыг туршиж үзэх тал дээр ажилтнуудад урам зориг өгч, дэмжих
- Дэвшүүлсэн санааны эхний хөгжүүлэлтийг дэмжих зорилгоор инновацид зориулан төсөв тусгаарлан (ring-fenced budget) төлөвлөх
- Судалгаа шинжилгээн дээр үндэслэсэн дижитал инновацид түншээр оролцох боломжийг оюутнуудад олгох
- Дижитал бүтээлч байдлыг дэмжихийн тулд шинээр арга хэмжээ, шагнал урамшуулал, санаачилга, санхүүжилтийн урсгал үүсгэн бий болгох
- Дижитал технологийн чиглэлүүдээр мэргэшсэн тэргүүн туршлагын төвүүдийг дэмжиж, мэдлэг, чадварыг нь байгууллага дотроо ашиглах нөхцөлөөр хангах
- Бизнес сэтгэлгээний соёлыг идэвхжүүлэх, олон нийтэд нэмэр тустай санаачилгуудад дэм үзүүлэх; оюутнуудад бизнес эрхлэх ур чадварыг бий болгох





Өргөн хүрээний нөлөөлөл

Судалгаа, инновацын төслүүдийн үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, тодорхой бүлгүүдэд зохих журмаар түгээх.

Чиглэл / зарчим/ үнэт зүйл

Дижитал бүлэг үүсгэх | Олон улсын үйл ажиллагаа | Орон нутгийн иргэд | Орон нутгийн/Бүс нутгийн/Үндэсний/ нөлөөлөл | Маркетинг ба харилцаа холбоо

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Байгууллагын судалгаа шинжилгээ, бизнес, инновацын үйл ажиллагааны орон нутаг, бүс нутаг, үндэсний болон олон улсын хэмжээнд (аж үйлдвэрийн, бизнесийн, судалгааны гэх мэт) үзүүлэх нөлөөнд дүн шинжилгээ хийж, бүртгэх.

Байгууллагын үүсгэн, бий болгосон оюуны капиталыг оролцогч талуудад түгээхдээ зохих төрөл, формат руу хувиргах

Байгууллагын дижитал хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийг дэмжиж, тэдэнд вэбсайтын дизайн, дижитал брэндинг, нэр хүндийн бодлого, дижитал контент үйлдвэрлэх болон бусад дижитал чиглэлээр мэдлэг, туршлагаа хөгжүүлж, үр бүтээлтэй ашиглахад нь туслах

Технологийн хөрөнгө оруулалт, технологийг хэрэгжүүлэн, ашиглах талаар байгууллагын гаргасан шийдвэрийн бизнесийн үйл ажиллагаанд (жишээлбэл, боловсрол, судалгаа, байгаль орчинд үзүүлэх нөлөө) үзүүлэх нөлөөг ойлгох, шүүмжлэх.

Инновац, судалгааг сайжруулах санаачилгуудын нөлөөллийг хэмжих механизмыг бий болгох

Үйл ажиллагааны жишээ


- Ажилтнууд болон оюутнуудыг өөр өөр бүлгийн хүмүүст зориулж дижитал контент бүтээхэд нь зохих технологиор хангаж, дэмжлэг үзүүлж, сургалтад хамруулсан байх
- Байгууллагын бүтээсэн контент болон бусад бүтээгдэхүүн, мөн гол санаа буюу мессежийг үр дүнтэй түгээх, брэнд болгох, хадгалах, удирдах зорилгоор маркетинг, харилцаа холбоог үр ашигтай байлгах





Мэдлэг дээшлүүлэх

Бүх оролцогч талуудын дижитал орчинд сурч, ажиллаж, хөгжих боломжийг хангахын тулд байгууллагын хүрээнд мэдлэг дээшлүүлэх, хөгжиж боловсрох явдлыг дэмжих. Дижитал хэлбэрээр суралцах, заах, үнэлэх арга замыг дахин бодож, сайжруулах.





Сургалтын хөтөлбөр боловсруулах

Хичээлийг хянах, төлөвлөх, боловсруулах. Үүнийг ерөнхийд нь төгсөлтийн үр дүн болон жишиг үзүүлэлтүүдтэй харьцуулж, мэргэжлийн стандартуудад нийцүүлсэн, тодорхой баримт бичиг (жишээ нь, хичээлийн гарын авлага, хуваарь, виртуал сургалтын орчны материалууд) хэлбэрээр боловсруулан гаргадаг, хэлтсийн болоод байгууллагын түвшний албан ёсны үйл явц хэмээн тодорхойлж болно.

Чиглэл / зарчим / үнэт зүйлс

Үнэлгээ, дүгнэлт | Сургалтын хөтөлбөрийн загвар | Сургалтын хөтөлбөрийн тогтолцоо | Дижитал чадавх | Дижитал стратеги | Олон улсын үйл ажиллагаа | Сургалтын загвар | Сургалтын хэлбэрүүд | Сургалтын нөөц хэрэгсэл | Суралцах заах үнэлэх стратеги | Магадлах

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Дижитал сургалт, технологид суурилсан сургалт, дижитал боловсрол эсвэл түүнтэй адилтгах боловсролд зориулсан стратеги ба/буюу тогтолцоог боловсруулж алба, хэлтэс, нэгжүүдэд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Сургалтын хөтөлбөр боловсруулах, дижитал хэлбэрээр суралцах, заах үйл ажиллагааг дэмжихийн тулд сургалтын нөөц, материал, хэрэгсэл хөгжүүлж, ашиглах стратеги, бодлого боловсруулан гаргах (жишээлбэл, боловсролын нээлттэй нөөц материал, цахим ном, цахим сэтгүүл болон бусад дижитал контент үүсгэх, ашиглах).

Технологид суурилсан сургалтын стратегийг байгууллагын бусад стратегитай (жишээ нь: мэдээллийн технологийн буюу дижитал стратеги, эд хөрөнгийн стратеги, үндэстэн дамнасан боловсрол, оюутны туршлага) уялдуулах.

Дижитал үнэлгээний буюу үнэлгээний цахим удирдлагын стратеги боловсруулж алба, хэлтэс, нэгжүүдэд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Бүх оюутнууд хүрсэн ололт, амжилтаа батлан харуулах боломжтой үнэлгээний системийг загварчлан бий болгох, үүнд дижитал хэрэгсэл, дижитал хэвлэл мэдээллийн хэрэгслийг зохих байдлаар ашигладаг байх

Дижитал чадавхыг хичээлийн хөтөлбөрт суулгаж өгөх, мөн дижитал сургалтын үр дүнтэй, жинхэнэ боломжуудыг загварчлан бий болгоход сургалтын хөтөлбөрийн багуудад дэмжлэг үзүүлж хөрөнгө оруулах.

Одоо суралцаж буй оюутнуудын боломжийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын өөр хэлбэрүүдийг судалж, эдгээрийг хэрэгжүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааны хүрээг тэлж, өргөжүүлэх талаар авч үзэх (жишээлбэл, зайн сургалт, МООС буюу нийтэд нээлттэй онлайн сургалт, онлайн сургалт, холимог/хосолмол сургалт).

Сурган хүмүүжүүлэх арга зүйд гарсан шинэ санаачилгуудыг хэрэгжүүлэх замаар, мөн түүнчлэн сургалтын хөтөлбөр боловсруулахад оюутнуудыг татан оролцуулах замаар заах, сурах сургалтын үйл явцыг шилдэг болгох соёлыг төлөвшүүлэх.

Ирээдүйд элсэх оюутнуудын өөрчлөгдөн хувьсаж буй хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцүүлэхийн тулд дижитал болон онлайн сургалтын талаарх судалгааг дэмжин явуулах.

Төгсөгчдийн ажил мэргэжил, амьдралын замналд гарах удаан хугацааны өөрчлөлтөд (чиг хандлага, хэтийн төлөвийн дүн шинжилгээнээс), мөн одоогийн хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөр төлөвлөлтийг хийх.

Үйл ажиллагааны жишээ

- Хувьсан өөрчлөгдөж буй стратегийн алсын хараа, ажил олгогчийн хэрэгцээ ба/буюу идэвхтэй холимог сургалт, хувь хүнд чиглэсэн сургалт, хосолсон сургалт, салбар дамнасан сургалт зэрэг тогтолцоонуудад нийцүүлэн байгууллага даяар хичээлүүдийг өөрчилж, хөгжүүлэн ажиллах
- Дижитал аргачлалын боломжуудыг бодит амьдралд хэрэгжүүлэхийн тулд ажилтнууд болон оюутнуудад шаардлагатай дижитал чадавхыг эзэмшүүлж, уламжлалт үнэлгээний болон санал дүгнэлтийн системийг эргэн харж, шинэчлэн боловсруулах
- Холимог сургалтыг өргөн хүрээнд явуулах боломж олгох эдийн засгийн загваруудыг судлах
- Сургалтын олон улсын шинэ хөтөлбөрүүдийг тодорхойлон үүсгэж, хэрэгжүүлэх
- Дижитал технологи ашиглан суралцах чадавх, ажилтнуудын чадавх нэмэгдэж байгаатай холбогдуулан эрэлт нь нэмэгдэж буй курс, хичээлүүдийн шинэ глобал зах зээлийг судалж үзэх
- Оюутнуудын сурах үйл явцыг уян хатан болгох, оролцоог сайжруулах боломж нөхцөлийг бүрдүүлэхэд дижитал болон бодит орон зайг хэрхэн ашиглаж буй/ашиглаж болохыг судлах





Дижитал технологи ашиглан суралцах

Дижитал төхөөрөмж, мэдээллийн хэрэгсэл, орчин, эсвэл дижитал программаар дамжуулан суралцах үйл явц. Дижитал сургалт нь шууд биечлэн, шууд онлайнаар эсвэл асинхрон буюу шууд бус хэрэгсэл, орчноор дамжуулан явагдах боломжтой.

Үүнд ажилтнуудын дижитал сургалт, хөгжил, түүнчлэн оюутнуудын албан болон албан бус сургалтууд багтана.

Чиглэл / зарчим / үнэт зүйлс

Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Дижитал чадавх | Дижитал ядуурал | Үр бүтээмжтэй дижитал суралцагчид | Э-портфолио | Уян хатан сургалт | Сургалтын орон зай | Номын сан, сургалтын нөөц | Хувь хүнд чиглэсэн сургалт | Бие даан зохицуулах | Оюутны сонголт | Оюутан суралцах | Оюутны ахиц | Оюутанд үзүүлэх дэмжлэг | Сурах орон зай

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Суралцагчдын дижитал чадавхыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор суралцагчид өөрсдөө бие даан нэвтрэн орж буюу хандан ашиглах боломжтой нөөц хэрэгсэлд хөрөнгө оруулах.

Суралцагчдыг амжилтаа бүртгэх, тодорхой хугацаанд гаргасан ахиц дэвшлээ эргүүлэн хянах механизм, боломжоор хангаж, дэмжих.

Суралцагчдын зөв сонголт хийх, сургалтын шаардлагуудыг хангах, ахиц дэвшил, амжилтанд хүрэхэд хэрэгтэй номын сан болон мэдээллийн үйлчилгээ, дижитал материалын цуглуулга, мэдээллийн багц, цаашдын заавар удирдамж, дэмжлэг гэх мэт бүх дижитал мэдээлэлд бодитоор болон зайнаас саадгүй хандах нөхцөлийг бүрдүүлэх

Дижитал суралцагчдын олон янз хэрэгцээг тодорхойлох, ялангуяа ядуурал, хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн эрүүл мэнд, оршин суугаа байршил, хэл, соёлын ялгаа эсвэл аливаа бусад хүртээмжтэй холбоотой гм асуудлаас болж оролцоо нь хангагдахгүй болох эрсдэлтэй хүмүүсийн хэрэгцээг тодорхойлох. Оюутнуудын өмнөх дижитал туршлагыг, ялангуяа ялгаатай өөр туршлагыг (жишээлбэл, гадаад оюутнуудын) баталгаажуулан зөвшөөрөх. Хүртээмжтэй, тэгш оролцоог хангасан зайнаас болон биечлэн суралцах бололцоог бүрдүүлэх аргачлалуудыг хөгжүүлэх.

Оюутан, суралцагчдын дижитал технологийг ашиглан суралцах ур чадварыг хөгжүүлэхэд зохих ёсоор тусалж, чиглүүлэх дэмжлэг үзүүлэх үйлчилгээнүүдэд хөрөнгө оруулах.

Суралцагчдад сонгосон мэргэжилд нь шаардагдах дижитал ур чадваруудын талаар ойлгуулж, сургалтынхаа туршид шаардлагатай ур чадваруудаа дадлагажуулан хөгжүүлэх боломж олгох.

Суралцагчдыг өөрсдөө бие даан суралцахыг дэмжих дижитал боломжуудаар хангах.

Суралцагчдад тухайн хичээлийн техникийн шаардлагуудын талаар тодорхой зааварчилгаа өгөх (жишээ нь техник хангамж, програм хангамж, нэвтрэх эрх гэх мэт).

Гуравдагч талын хөгжүүлсэн болон хиймэл оюунд суурилсан платформуудыг оруулаад оюутнууд ашиглах боломжтой байгаа дижитал хэрэгсэл, нөөцүүдийг ойлгон тодорхойлж, оюутнуудад эдгээрийг сургалтын орчинд үр дүнтэй, үнэнч шударга, ёс зүйтэй ашиглахад нь дэмжлэг үзүүлэх.

Оюутан, суралцагчдад сургалтын хэрэгцээ, хувийн нөхцөл байдалдаа тохируулан онлайнаар, биечлэн, эсвэл холимог горимоор суралцахад нь дэмжлэг үзүүлэх.

Үйл ажиллагааны жишээ

- Оюутны хичээл судлах хугацааны туршид зохих санал зөвлөмжийг цаг тухай бүрт нь өгч, оюутныг суралцах үйл явцаа өөрөө зохицуулах боломжтой болгох зорилгоор бодит болон дижитал аргуудыг тэнцвэртэй ашиглах
- Суралцагчдыг бодит болон дижитал аргуудыг хослуулан суралцах замаар дижитал технологийн болон сургалтын хэрэгцээ, шаардлагаа бие даан үнэлэх, тодорхойлох, илэрхийлэхэд нь урамшуулан дэмжих
- Суралцагчдад дижитал хэлбэрээр суралцах чадавхаа үнэлэх, үүн дээрээ тулгуурлан ямар дэмжлэг хэрэгтэй байгаагаа тодорхойлох боломжийг тогтмол санал болгох
- Суралцагчдыг сурч мэдсэнээ эргэцүүлэн дүгнэхэд нь зохих дижитал хэрэгслээр хангаж, дэмжих (жишээ нь э-портфолио, хувийн блог)

Чиглэл / зарчим / үнэт зүйлс

Дижитал чадавх | Уян хатан зохицуулалттай ажлын байр | Ажилтнуудын хөгжил | Ажилтан ажилд авах, ажилд үлдээх

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Байгууллагад ажиллаж буй бүх ажилтнуудад зориулан хувь хүний / мэргэжлийн дижитал хөгжлийн боломжуудад хөрөнгө оруулалт хийх.

Байгууллагын хэмжээнд дижитал сургалтын үйл ажиллагааг дүгнэх, үнэлж, урамшуулах боломжуудыг бий болгон, хэрэгжүүлэх.

Үйл ажиллагааны жишээ

- Оюутны уян хатан суралцах, оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөрийн багуудыг дижитал чадавхын түвшингээ үнэлэх, дүгнэх, түүнчлэн хөгжүүлэх шаардлагатай байгаа мэргэжлийн чиглэлүүдээ тодорхойлох боломжоор хангах





Дижитал технологи ашиглан заах

Дижитал төхөөрөмж, мэдээллийн хэрэгсэл, орчин, эсвэл дижитал программаар дамжуулан заах үйл явц. Дижитал технологиор дамжуулан заах үйл явц нь шууд биечлэн, шууд онлайнаар эсвэл оюутнуудыг янз бүрийн асинхрон буюу шууд бус нөөц хэрэгсэл, орчноор дамжуулан дэмжих замаар явагдах боломжтой. Мөн оюутнуудын дижитал суралцах чадварыг нь дэмжинэ.

Чиглэл / зарчим / үнэт зүйлс

Үнэлэх, дүгнэх | Дижитал чадавх | Өгөгдлийн аналитик | Сургалтын орчин | Сургалтын материаллаг бааз | Сургалтын технологич | Сургалтын нөөц хэрэгсэл | Номын сан, сургалтын нөөц | Нээлттэй сургалтын туршлага | Нээлттэй боловсролын нөөц | Ажилтны хөгжил | Оюутанд үзүүлэх дэмжлэг

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Виртуал сургалтын орчин / сургалтын удирдлагын систем, үнэлгээ дүнгийн систем, э-портфолио, аналитик, баяжуулсан бодит байдал / виртуал бодит байдал зэрэг дижитал хэлбэрээр суралцах, заах дэд бүтцэд хөрөнгө оруулах.

Сургалтанд биечлэн, онлайнаар шууд болон асинхрон буюу шууд бусаар оролцох үйл ажиллагааг дэмжих олон төрлийн дижитал платформд хөрөнгө оруулалт хийж, удирдах.

Оюутнуудад өөр өөр орон зай, платформ ашиглан сургалт явуулахад шаардагдах заах арга зүйн олон өөр ур чадвар шаардагдана гэдгийг хүлээн зөвшөөрч, тэдгээр ур чадвараа хөгжүүлэхэд нь ажилтнууддаа дэмжлэг үзүүлэх. Багшлах боловсон хүчний анхан шатны болон тасралтгүй үргэлжлэх мэргэжлийн хөгжилд эдгээр болон бусад дижитал чадавхыг суулгаж өгөх.

Дижитал ур чадвар, мэдлэг туршлагатай багшлах боловсон хүчнийг сонгон шалгаруулж, хөгжүүлж, тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх

Суралцах, заах, үнэлэх арга барилд дижитал технологийг нэвтрүүлэх.

Дижитал аргачлалыг нэвтрүүлснээр аливаа саад бэрхшээлийг арилгахад хувь нэмэр оруулах, сургалтын үйл явцад шинээр саад бэрхшээл үүсгэхгүй байхад анхаарч ажиллах

Бодит амьдрал дээрх ажлын орчныг тусгасан ажлын байрны ур чадваруудыг тодорхойлж, сургалтын үйл явцад (суралцах, заах, үнэлэх) суулган, оруулж өгөх.

Заах аргыг хөгжүүлэх, сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцыг мэдээллээр хангах зорилгоор сургалтын аналитик үр дүнг ёс зүйтэй хэрэглэх стратегийг судалж, боловсруулах.

Бүлгээр, ганцаарчлан болон зайнаас суралцах, заах үйл ажиллагааг дэмжихийн тулд тохирох холболт, тоног төхөөрөмж бүхий төрөл бүрийн сургалтын орон зайд хөрөнгө оруулж, удирдах.



Суралцагчид суралцах хугацааныхаа туршид багш, хамт суралцагчид, болон өөр бусдаас ойлгомжтой зөвлөмж, шүүмж, дүгнэлтийг цаг тухайд нь хүлээн авдаг байх нөхцөлийг хангаж олон төрлийн дижитал аргачлал ашиглах.

Дижитал сургалтын хүртээмжтэй нөөц хэрэгслийг хөгжүүлж, зохистой ашиглахад дэмжлэг үзүүлэх механизм бий болгож, бодлого боловсруулах.

Аж үйлдвэрийн зохих стандарт, шаардлагуудыг хангасан, оюутнуудад "бодит амьдрал"-ын туршлага, жинхэнэ бодит дадлага хийх боломжоор хангах технологиудад хөрөнгө оруулах.

Үйл ажиллагааны жишээ

- Ирц бүртгэл, хичээлийг үзэж дүүргэсэн хүний тоо зэрэг энгийн өгөгдлөөс гадна дижитал сургалтын амжилтыг дүгнэхэд ашиглаж болох үзүүлэлтүүд, аналитик хэмжүүр бий болгох
- Ажилтнуудын дижитал чадавхыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажилтнууд өөрсдөө бие даан нэвтрэн орж буюу хандан ашиглах боломжтой нөөц хэрэгсэлд хөрөнгө оруулах

- Суралцагчдын хэрэгцээ, хүсэл сонирхлыг тодорхойлж, түүнд тохирсон сургалтын туршлагыг бий болгохын тулд хиймэл оюун ухааны хэрэглээг судлах

- Багшлах боловсон хүчнийг албан болон албан бусаар дижитал мэдлэг, туршлагаа хуваалцах боломжоор хангах

- Дижитал чадвараа хөгжүүлж буй багш ажилтнуудыг үнэлж, урамшуулах (жишээ нь: гүйцэтгэлийн болон ур чадварын үнэлгээ, ажлын цагаас дижитал ур чадварын хөгжилд зориулж хугацаа хуваарилах, тушаал дэвшүүлэх, мэргэжилтний албан тушаал санал болгох, дижитал чадавхыг шагнал, хүндэтгэл, сайшаалын системд оруулж, уялдуулах)

- Үнэлгээ, дүгнэлтийн механизмын удирдлага, хэрэгжилтийг дахин загварчлах

- Дэлхийн аль ч хэсэгт оршин сууж буй оюутнуудад өндөр чанартай үйлчилгээ хүргэх зорилгоор технологи ашиглах

- Суралцах, заах, үнэлэх үйл явцад дижитал аргачлалыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор чанар сайжруулах процессуудыг дижитал сургалтын хэлбэрт тохируулан шинэчлэх

- Холимог/хосолсон сургалттай холбоотой технологи нэвтрүүлэхэд тулгарч буй саад тотгорыг тодорхойлохын тулд оролцогч талуудтай хамтран ажиллаж, уг асуудлыг зөв шударгаар шийдвэрлэх арга замыг хайж олох (жишээ нь, зайнаас сурч буй оюутнуудын камерыг асаах/унтраах, дижитал холбоо харилцааны байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулах гэх мэт)

- Биечлэн сургалтын танхим, тоног төхөөрөмж ашиглан сургалтанд хамрагдах боломжгүй хүмүүст зориулж мэдлэгийг бодит амьдралд хэрэгжүүлж дадлагажих өөр арга хэрэгслийг тодорхойлох (жишээ нь, тоглоом, симуляци)

- Цахим номын хүртээмжийг нэмэгдүүлэх, үнийг боломжийн болгох үүднээс бусад их дээд сургуулиудтай хамтран консорциум байгуулж хэвлэлийн компаниудад санал тавьж, зөвшилцөлд хүрэх





Суралцагчийн туршлага

Хөтөлбөрийн дагуу заасан хичээлүүд болон хичээлээс гадуурх дараах үйл ажиллагаануудыг оруулаад тухайн суралцагчийн суралцах хугацаандаа хуримтлуулсан нийт туршлага: хувиараа бие даан суралцах хэлбэр, суралцах ур чадвараа хөгжүүлэхэд авсан дэмжлэг, номын сангийн нөөц хэрэгсэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох дэмжлэг, хамтран суралцах албан бус сургалтын хэлбэр гэх мэт. Сэтгэл санааны болон хувийн сайн сайхан байдлыг мөн оруулна.

Чиглэл / зарчим / үнэт зүйлс

Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Дижитал бүлэг үүсгэх | Дижитал цогц чадвар | Дижитал оролцоо | Дижитал сайн сайхан байдал | Олон улсын үйл ажиллагаа | Харьяалагдах хэрэгцээ | Оюутны туршлага | Оюутанд үзүүлэх дэмжлэг

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Дижитал сургалтын туршлага дээр суурилан, жишиг тогтоож, сайжруулалт хийхийн тулд суралцагчидтай хамтран ажиллах.

Дижитал чадавхаа хөгжүүлсэн оюутнуудыг урамшуулах (жишээ нь, байгууллагад дадлага хийх боломж, хувь хүний хөгжлийн боломж, хичээлээс гадуурх идэвх зүтгэлийг үнэлсэн шагнал, дижитал тэмдэг, дижитал ур чадвартай болоод төгсөх).

Танилын хүрээгээ тэлэх, бусадтай найзалж нөхөрлөх, сургуулийнхаа нэг хэсэг гэдгийг мэдрэх, эрүүл, сайн сайхан байх, олон нийтийн ажилд оролцох зэрэг хувь хүний хөгжлийн боломжуудыг хангах дижитал стратегиудыг нэвтрүүлэх, суралцагчдын туршлагыг илүү өргөн хүрээнд, байгууллагын хэмжээнд авч үзэх.

Оюутнуудад дэмжлэг үзүүлэх, тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хангах зорилгоор бодит болон дижитал хэлбэрийн олон янзын механизм хэрэгжүүлэн ашиглах.

Оюутнуудыг элсэлтийн өмнөхөөс авахуулаад төгсөлтийн дараах хүртэл бүх үе шатанд жигд тогтвортой туршлага хуримтлуулах боломжоор хангахын тулд технологи ашиглах.

Үйл ажиллагааны жишээ

- Хичээлдээ суусан, ажлаа хийсэн хугацааг арай өөр хэлбэрээр, шууд эсвэл шууд бус (синхрон эсвэл асинхрон) байдлаар батлан харуулах боломжтой ирц бүртгэлийн (ажилтнууд болон оюутнуудын хувьд) ойлголтыг нэвтрүүлэх
- Оюутны сайн сайхан байдалтай холбоотой өргөн хүрээг хамарсан санаачилга, үйлчилгээнүүдэд оюутны дижитал сайн сайхан байдлыг оруулах
- Судалгаа хийх, санал асуулга авах ба/буюу зөвлөж лавлах замаар суралцагчдын олж хуримтлуулсан дижитал туршлагыг идэвхтэй судлан, ойлгож мэдэх
- Хувь хүнд чиглэсэн, хэрэгцээ шаардлагад нийцүүлэх боломжтой сургалт явуулж, үнэлэхэд технологи ашиглах

Технологид суурилсан болон биечилсэн сургалтын аргуудыг тэнцвэртэй ашиглах

- замаар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох дэмжлэг үзүүлэх, ажилд зуучлах, хөдөлмөрийн зах зээлд шаардагдах ур чадварыг хөгжүүлэх нөхцөлөөр хангах

Суралцагчдыг хичээлээ судалж эхлэхийн өмнө технологийн олдоц, хүртээмж, сүлжээ холболт, сургалтын орон зай буюу орчин нөхцөлийнх нь талаар олж мэдэх асуулга явуулж, ямар нэмэлт дэмжлэг хэрэгтэй болохыг нь олж мэдэх

- Олон улсын (өөр улсад биеэр хүрэлцэн ирж суралцаж буй) болон үндэстэн дамнасан боловсролын (өөр улсад зайнаас суралцаж буй) оюутнуудын харьяалагдах хэрэгцээ нь хангагдаж, үр дүнтэй суралцахад шаардлагатай дэмжлэг, тусламж үзүүлэхэд анхаарах

Дэлхий даяарх оюутнуудын шилжилт хөдөлгөөн, энэхүү глобал хөдөлгөөний


- үйлчилгээ авах, суралцах, дэмжлэг тусламж авахад үзүүлж болох нөлөөллийг авч үзэх





Мэдлэгийг удирдах, хэрэглэх

Байгууллагын үйл ажиллагааны бүхий л чиглэлийг, тэр дундаа судалгаа, сургалт явуулах үйл ажиллагааг дэмжиж өгөгдөл, мэдээллийн хүртээмж, ашиглалтыг сайжруулах. Шийдвэр гаргах үйл явцыг мэдээллээр хангах зорилгоор мэдээлэл болон өгөгдлийг нэгтгэх, хадгалах, удирдах, хуваалцах, ашиглах боломжтой байх.





Мэдээллийн удирдлага, хэрэглээ

Мэдээллийг үр дүнтэй олж татан, ашиглах боломжтой байхаар цуглуулж, цэгцэлж, хадгалж, хуваалцахтай холбоотой арга барил, журмууд.

Үүнд байгууллагын үүсгэсэн болон гуравдагч талаас нийлүүлсэн мэдээлэл орно.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Дижитал цуглуулгын удирдлага | Дижитал мэдээлэл | Дижитал мэдээллийн хэрэгсэл | Дижитал хадгалалт | Мэдээллийн боловсрол | Мэдээллийн стратеги | Мэдээлэл хадгалалт, таталт | Номын сан, сургалтын нөөц хэрэгсэл | Удирдлагын мэдээлэл | Сурах орон зай

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Байгууллагын мэдээллийн стратегийг боловсруулах; мэдээллийн удирдлага болон хууль, журмын хэрэгжилттэй холбоотой бодлого, протокол боловсруулах.

Номын сан, мэдээллийн үйлчилгээнд стратегийн зохистой өөрчлөлт оруулах үүднээс оролцогч талуудын хэрэгцээг тусгах, хэрэглэгчидтэй итгэлцэл бүхий харилцаа үүсгэхэд анхаарах.

Байгууллагын мэдээлэл удирдах системүүдэд хөрөнгө оруулах; стратегийн зорилтуудыг дэмжих инновацын төслүүдийг хэрэгжүүлэх.

Байгууллагын номын сан, мэдээллийн ажилтнуудад дэмжлэг үзүүлж, өгөгдөл, мэдээллийн удирдлага, оюуны өмчийн эрх, лиценз, дижитал нөөц хэрэгсэл, нээлттэй хэвлэл, боловсролын нээлттэй агуулга, мэдээллийн боловсрол, дижитал хадгалалт, сургалт, нөөцийг дижитал хэлбэрт оруулах, дижитал цуглуулгын удирдлага чиглэлүүдээр мэдлэг, чадвараа дээшлүүлж, ашиглахад нь туслах.

Ажилтнууд/оюутнуудын мэдээллийн боловсрол, мэдлэгийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх таатай орчин бүрдүүлэх; Мэдээллийн боловсролыг сургалтын хөтөлбөр, судлаачид болон ажилтнуудыг хөгжүүлэх сургалт, хөтөлбөрүүдэд оруулсан байх.

Номын сан болон мэдээллийн чиглэлээр мэргэжилтэн ажилд авах, хөгжүүлэх, тогтвортой ажиллуулах боломжийг бүрдүүлэх

Бизнес процесс, үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ажилтнууд байгууллагын дижитал мэдээллийг цуглуулах, нэгтгэх, удирдах, ашиглах боломжтой байх.

Судалгаа, сургалт, гадаад түншлэлийн үр дүнд бий болсон оюуны өмчийг үр дүнтэй дижитал удирдлагаар хангах бодлого боловсруулах.

Дижитал эрдэм судалгааны ажил, холимог болон судалгаанд суурилсан сургалт болон сургалт, судалгааны оролцоо өссөнтэй холбоотой тэргүүлэх чиглэлүүдийг (жишээлбэл, судалгаа хийхэд цахим тооцооллын арга ашиглах, дижитал цуглуулгыг өгөгдөл болгон ашиглах) дэмжих зорилгоор зохих дижитал номын сан, архивын цуглуулгыг үүсгэн хөгжүүлэх/худалдан авах, эмхлэх, хадгалах

Үйл ажиллагааны жишээ

- Байгууллагын төлөвлөлтийг хийх, шийдвэр гаргах, асуудал шийдвэрлэх, байгууллагын гүйцэтгэлд хяналт тавих үйл явцуудыг үр дүнтэй явуулахад дижитал мэдээллийг ашиглах
- Дижитал мэдээллийн үнэн зөв байдал, эх үүсвэр, холбоо хамаарал, үнэ цэн, найдвартай байдалтай холбогдуулан ажилтнууд болон оюутнууд шүүмжлэлтэй хандаж болдог байх
- Ажилтнууд болон оюутнуудыг хууль эрх зүйн шаардлага, байгууллагын зарчмуудын талаар бүрэн мэдээллээр хангах зорилгоор зохиогчийн эрх, мэдээлэл хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал, нээлттэй лиценз, оюуны өмчийн эрхийн талаарх удирдамж боловсруулах
- Мэдээлэл/номын сангийн үйлчилгээ үзүүлэхэд хиймэл оюун ухааныг ашиглах талаар судлах
- Байгууллагын архивлалттай холбоотой үүрэг, хариуцлагыг тодорхойлох





Өгөгдлийн удирдлага, хэрэглээ

Өгөгдөлд суурилсан байгууллагын шийдвэр гаргах үйл явцыг дэмжихийн тулд үр дүнтэй дүн шинжилгээ хийж, ашиглах боломжтой арга замаар өгөгдлийг цуглуулж, зохион байгуулж, хадгалж, хуваалцахтай холбоотой арга барил, журам гаргах. Үүнд бүх хэлбэрийн өгөгдлийн ёс зүйт хэрэглээ, чанар, засаглал, стандарт, аюулгүй байдал, хууль журмын хэрэгжилт зэрэг багтана

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Бизнесийн үйл явц, үйл ажиллагаа | Хууль журмын хэрэгжилт | Кибер аюулгүй байдал | Өгөгдлийн архитектур | Өгөгдлийн аналитик | Өгөгдлийн ёс зүй | Өгөгдлийн боловсрол | Өгөгдлийн нууцлал | Өгөгдлийн чанар | Өгөгдлийн стратеги | Бизнесийн архитектур | Ёс зүй | Аюулгүй байдал, бизнесийн тасралтгүй байдал

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Үр дүнтэй хөрөнгө оруулалт хийх, өгөгдлийн стратегийг хэрэгжүүлэх, өгөгдлийг дижитал хэлбэрээр хадгалах, өгөгдлийг тайлбарлах / дүн шинжилгээ хийх арга замаар бизнесийн оюуныг ашиглах системтэй аргачлалыг онцлон авч үзсэн дижитал өгөгдлийн стратеги (илүү өргөн цар хүрээг хамарсан дижитал стратегийн нэг хэсэг болон орсон байж болно) боловсруулах.

Бизнесийн архитектурыг шинэчилсэн байх, мөн өөрчлөгдөн буй бизнесийн үзэл баримтлал, үйл явц, шийдлүүдийн хөгжил, дэвшилтэй уялдуулсан байх.

Найдвартай, сайтар төлөвлөсөн өгөгдлийн архитектур (өгөгдөл цуглуулах, удирдах, шинжлэх, ашиглахад зориулагдсан загвар, бодлого, дүрэм, стандартуудаас бүрдэнэ) бий болгоход хөрөнгө оруулах.

Өгөгдлийн чанар, өгөгдлийн удирдлага, хууль журмын хэрэгжилтийг хангах протокол гаргах зэргээр өгөгдлийн зохистой засаглал, үүрэг хариуцлагыг байгууллага даяар бий болгох

Судалгааны өгөгдлийн удирдлага, сургалтын аналитик гэх мэт инновацын төслүүд хэрэгжүүлж, судалгаа хийх.

Байгууллагын зүгээс хувь хүний дижитал өгөгдлийг аюулгүй, ёс зүйтэй удирдах, архивлах, ашиглах талаар бодлого боловсруулахдаа оролцогч талуудтай хамтран ажиллах.

Оролцогч талуудад өөрсдийгөө болон мэдээллээ хамгаалахад нь туслах зорилгоор шилдэг туршлага хэрэгжүүлсэн заавар зөвлөмж, удирдлагаар хангах.

Байгууллагын хэмжээнд зохих шаардлагатай өгөгдлийн ур чадвар бүхий ажилтнуудыг ажилд авах, ур чадварыг нь хөгжүүлэх, ажилд нь тогтоон барих буюу тогтвортой ажиллуулах боломжийг бүрдүүлэх.

Ажилтнуудад албан тушаалын үүргийнхээ дагуу байгууллагын өгөгдлийг ашиглахад дэмжиж, сургах.

Өөр өөр бүлгийн оюутнуудын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор шаардлагатай өгөгдлийг тодорхой бүлгээр ангилан цуглуулах (жишээлбэл, олон улсын оюутнууд, гадаад дахь түншүүдийн үндэстэн дамнасан боловсролын мэдээлэл, хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд, асран хамгаалагчид).

Үйл ажиллагааны жишээ

- Өгөгдлийн удирдлагын арга барил, систем, үйлчилгээг шинэчилж, өөрчлөлт хийхдээ одоо байгаа бодлого, арга барилуудыг эргэн хянах
- Байгууллагад болон илүү өргөн хүрээндээ нийгэмд өгөгдлийн гүйцэтгэх үүргийг ойлгож, шүүмж өгөхдөө оролцогч талуудтай хамтран ажиллах
- Олон нийтийн суралцах, судлах хэрэгцээнд зориулж өгөгдлийг нээлттэй хуваалцах (өгөгдлийн нууцлал, аюулгүй байдалтай зөрчилдөхөөргүй байвал)
- Суралцагчдын туршлагыг илүү сайн ойлгох, улмаар сургалтын үр дүнг сайжруулахад ашиглах зорилгоор байгууллагын хэмжээнд өгөгдлийн бүх эх үүсвэрийг тодорхойлох (жишээ нь, номын сангийн нөөц ашиглалт, виртуал сургалтын орчин ашиглалт гэх мэт)





Бизнесийн оюун (BI)

Бизнес, стратегийн шийдвэрийг мэдээллээр хангах зорилгоор өгөгдөл, мэдээллийг цуглуулах, удирдах, ашиглах. Үүнд бизнесийн байгууллагуудын өгөгдлийн дүн шинжилгээ хийж, бизнесийн мэдээлэл удирдахдаа ашигладаг стратеги, технологиуд орно.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Суурь түвшин тогтоох | Жишиг түвшин тогтоох | Бизнесийн оюуны стратеги | Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөлт | Дижитал манлайлал | Дижитал стратеги | Ёс зүйтэй систем, процесс | Урьдчилсан таамаглал | Чиг хандлага тодорхойлох | Удирдлагын мэдээлэл | Зах зээлийн мэдээлэл | Нээлттэй, ил тод байдал

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Байгууллагын өгөгдлийг цуглуулах, удирдах, байгууллагын хэмжээнд тайлагнах, өгөгдөл хангамжийг зохицуулах стратегийн нэгдсэн аргачлал боловсруулах.

Стратеги болон хөрөнгө оруулалтын шийдвэрийг мэдээллээр хангах суурь үзүүлэлт, жишиг үзүүлэлтийг тогтоох зорилгоор зах зээлээс хэрэгцээтэй мэдээлэл цуглуулах механизмыг бий болгох.

Бизнесийн ухаалаг систем, бодлого, процессууд нь найдвартай, ёс зүйтэй, тогтвортой, хууль ёсны байх шаардлагатай.

Олон өөр төрлийн дижитал агуулгыг хамаарах систем, бодлого зохицуулалт, арга барил бүгд хоорондоо нийцсэн, уялдаа холбоотой байх; дижитал контент, мэдээллийг үүсгэх, ашиглах, удирдах зорилгууд, ерөнхий ашиглалттай холбоотой байгууллагын хэмжээнд итгэлцэл, ойлголцлыг бий болгох.

Ажилтнууд бизнесийн багтай ажиллахдаа төсөл хөтөлбөрийн шаардлага хэрэгцээг ойлгох, хөгжлүүлэлтийг дэмжин явуулах, тайлан гаргах, мэдээллийг дүрслэн харуулах зэрэг техникийн болон аналитик ур чадваруудыг зөв хослуулан эзэмшсэн байх.

Үйл ажиллагааны жишээ

- Байгууллагын эзэлж буй байр суурийг жишиж тодорхойлох (жишээ нь, судалгааны гүйцэтгэлийн чиглэлээр) зорилгоор зах зээлийн судалгаа хийж, мэдээлэл цуглуулах
- Байгууллагын удирдлагууд аж үйлдвэр, боловсрол, бизнесийн салбарт явагдаж буй дижитал шилжилтийн талаар мэдэж байх шаардлагатай бөгөөд зохих шинэ туршлага, арга барилыг (жишээлбэл, сургалтын хөтөлбөр боловсруулах, мэдлэгийн практик дадлууд) хэрвээ тохирохоор бол байгууллагадаа дэмжин нэвтрүүлэх

Байгууллагад мэдээлэл хэрхэн ашиглагдаж байгааг авч үзэх, мэдээллийн ашиглалтыг

- тодруулан үр дүнтэй хэрэглэх (жишээлбэл, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн тоо баримт дээр тулгуурлан оюутнуудын ажил мэргэжлийн чиг баримжааг тодорхойлох, оюутны элсэлтийн чиг хандлагаас ирээдүйн оюутнуудын тоо хэмжээг багцаалан гаргах)
 - Шийдвэр гаргахад ямар мэдээлэл нэн чухал болох, тэрхүү мэдээллийг хаанаас авах гм тайлан мэдээ гаргахад шаардлагатай нэн тэргүүний чиглэлүүд дээр зөвшилцөлд хүрэх
 - Зохих хэрэглэгчийн тодорхойлсон өгөгдөлд суурилсан хянах самбарт хандах эрхийг байгууллагын тодорхой албан тушаал бүхий хүмүүст олгох
- Хэрэгжилтийн хугацаанд шаардлага гарвал түр зуурын арга хэмжээ авахаар тооцож,
- бизнесийн оюуны үйлчилгээг нэвтрүүлэн хэрэгжүүлэх үе шаттай төлөвлөгөө гаргах буюу замын зураглал бий болгох

Зорилгодоо хүрэхэд шаардлагатай өгөгдөл цуглуулах ажлыг эрэмбэлэх (жишээ нь

- суралцагчийн аналитик дүн шинжилгээ хийхэд ирц бүртгэлийн мэдээ байх шаардлагатай)





Шийдвэр гаргах

Байгууллагын үйл ажиллагааны бүх чиглэлээр стратегийн зорилгод хүрэх арга замуудыг тодорхойлж, шийдвэр гаргахдаа, тухайлбал, хөрөнгө оруулалт хийх, төлөвлөх зэрэгт ашиглах нотолгоо буюу бизнесийн өгөгдөл, түүнийг боловсруулах технологид дүн шинжилгээ хийж, үнэлэх.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Дижитал итгэлийн түвшин | Дижитал нотолгоо | Дижитал цогц чадамж | Дижитал манлайлал | Дижитал алсын хараа | Асуудал шийдвэрлэх

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Шийдвэр гаргах үйл явцыг мэдээллээр хангах, чанар / дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор дижитал нотолгоо буюу өгөгдөл цуглуулах байгууллагын нэгдсэн систем, дижитал хэрэгслийг бий болгон, ашиглах.

Байгууллагын удирдлагуудын шийдвэр гаргах гэх мэт үйл явцыг дэмжих зорилгоор дижитал нотолгоо, дижитал хэрэгслийг үр дүнтэй ашиглах нөхцөл бүрдүүлэх.

Ирээдүйн төлөвлөлтийг чиглүүлж, түүнд нөлөөлөхүйц асуулт асууж, санал дүгнэлт гаргах мэдлэг чадвартай байх, оролцогч талуудын бүлгүүдээс нотолгоо буюу өгөгдөл цуглуулах янз бүрийн аргачлалыг бий болгох нөхцөл, боломжийг дижитал удирдагчдад бүрдүүлж өгөх.

Шилдэг туршлагыг хуваалцах, шийдвэр гаргах үйл явцыг оновчтой болгохын тулд байгууллага дотор үүссэн зааг, хязгааруудыг арилгах явдалд тууштай байх.

Хэтийн төлөв шинжиж, чиг хандлага тодорхойлох үйл ажиллагааны мэдээлэл дээр суурилан өдөр тутмын шийдвэр гаргах.


Дижитал стратеги, байгууллагын үнэт зүйлс нь бүх түвшний шийдвэр гаргах үйл явцад нөлөөлж, чиглүүлдэг байх.

Дижитал дэд бүтэц, стратеги, сургалтын хөтөлбөрийн талаар шийдвэр гаргахад суралцагч, багш, судлаачдыг гол оролцогч талууд болгон татан оролцуулах.

Үйл ажиллагааны жишээ


- Байгууллагын өөр өөр орчин нөхцөл дэхь бизнесийн үйл явцуудыг (жишээ нь, боловсрол, судалгаа, дэмжлэг үйлчилгээ), мөн дижитал технологийн тусламжтайгаар эдгээрийг хэрхэн идэвхжүүлж, хязгаарлаж болохыг ойлгох
- Байгууллагын дээд шатны удирдлах ажилтнуудад шийдвэр гаргах, төлөвлөхөд нь дэмжлэг үзүүлэх мэдээлэл, өгөгдөлд хандах эрх /боломж олгох





Мэдлэг солилцох, түншлэх

Байгууллагын гол мессежүүдийг дамжуулан түгээх, мөн бүх түнш/оролцогч талуудын хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоог дэмжих зорилгоор мэдлэгийн солилцоог нэмэгдүүлэх.





Харилцаа холбоо

Байгууллага нь оролцогч талуудын хоорондын харилцаа холбоог сайжруулан, дэмжих, түүнчлэн байгууллагын гол мессежийг гадагш түгээх зорилгоор дижитал технологи, сүлжээг хэрхэн ашиглах тухай авч үзнэ.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Дижитал харилцаа холбоо | Дижитал ёс суртахуун | Дижитал мэдээллийн хэрэгсэл | Дижитал сүлжээ | Маркетинг ба харилцаа холбоо | Байгууллагын харилцаа холбоо | Нийгмийн сүлжээ ашиглах

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Дижитал харилцаа холбооны дотоод болон гадаад дэд бүтцэд хөрөнгө оруулах. Дижитал байгууллагад байвал зохих ардчилсан харилцааг эрхэмлэх; мэдлэг солилцож, туршлага хуваалцах дотоод сүлжээг хөгжүүлэх.


Дижитал хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүндэтгэлтэй харилцахыг эрхэмлэх; дижитал харилцааны ур чадварыг сургалтын хөтөлбөр, ажилтны хөгжлийн хөтөлбөрт суулгаж өгөх. Дижитал хэвлэл мэдээллийн хэрэгслийн тэгш хүртээмжтэй байх журам зохицуулалтуудтай, мөн тэгш хүртээмж, тэгш оролцооны илүү өргөн хүрээг хамарсан байгууллагын зорилтуудтай нийцсэн байх нөхцөлийг хангасан удирдамж боловсруулж, дэмжлэг үзүүлэх.

Дижитал хэвлэл мэдээллийн хэрэгслийн контент үйлдвэрлэх, түгээх дэд бүтцэд буюу материаллаг баазад хөрөнгө оруулалт хийж, үр ашгийг нь хүртэх боломжтой байгууллагын бүх хүнд эдгээр үйлчилгээг хүртээмжтэй байлгах.

Дижитал хэвлэл, мэдээллийн хэрэгслийн чиглэлээр ур чадвартай, мэдлэг туршлагатай ажилтнуудыг ажилд авах, хөгжүүлэх, ажлын байранд нь үлдээх боломж, нөхцөлөөр хангах.

Үйл ажиллагааны жишээ

- Тэгш оролцоог хангасан дижитал харилцааны удирдамж (жишээ нь, ёс зүйн дүрэм, цахим шуудан буюу имэйлийн ёс зүй, онлайн зан үйлийг удирдах гэх мэт) боловсруулахдаа оролцогч талуудтай хамтран ажиллана.
- Онлайнаар дарамт үзүүлэх, дээрэлхэх явдлыг үл тэвчих соёлыг төлөвшүүлэх
- Дижитал контентийг ямар форматтай бүтээхээс (текст, зураг, видео гм), мессежийг ямар хэлбэрээр бичихээс хамаарч зорилго хэрхэн биелж байгааг, мөн дижитал медиа болон сүлжээнүүд нийгмийн зан төлөвт хэр зэрэг нөлөөлж байгааг авч үзэхдээ оролцогч талуудтай хамтран ажиллах
- Онлайн орчны харилцааг бүх оролцогч талуудын хувьд эрх тэгш, зөв зохистой, ойлгомжтой, тодорхой явуулах нөхцөлийг хангах үүднээс онлайн харилцааны синхрон буюу шууд, асинхрон буюу шууд бус аргуудын удирдамжийг боловсруулах



Хамтын ажиллагаа

Оролцогч талуудыг тодорхой тавьсан зорилгодоо хүрэхийн тулд бусадтай хамтран ажиллахад нь туслах зорилгоор дижитал технологийг байгууллага хэрхэн ашиглаж болох тухай авч үзнэ. Үүнд аюулгүй, тэгш хүртээмжтэй, тус дөхөмтэй ажлын болон сургалтын арга барилууд орно.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Олон нийтийн хамтын ажиллагаа | Дижитал хамтын ажиллагаа | Олон улсын үйл ажиллагаа | Нээлттэй хуваалцах | Ажилтнуудын хамтын ажиллагаа | Оюутны хамтын ажиллагаа

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Дотоод болон гадаад хамтын ажиллагааны дижитал орчинд хөрөнгө оруулалт хийх. Нээлттэй сургалтын материал гаргах, нээлттэй курс буюу хичээл явуулах, нээлттэй судалгаа шинжилгээний материал хэвлүүлэх зэрэг нээлттэй арга барилаар дамжуулан мэдлэг хуваалцах, солилцохыг дэмжих; хамтын ажиллагааны туршлагыг сургалтын хөтөлбөр, ажилтныг хөгжүүлэх хөтөлбөрт оруулах.

Байгууллагын дотоод зааг, хязгаарыг дамнасан хамтын ажиллагааг дэмжих (жишээлбэл, төслийн баг, ажлын хэсэг).


Дижитал хамтын ажиллагааны соёлыг өргөн хүрээнд бий болгоход үүсэж болох боломжууд, учирч болох эрсдлүүдийг тодорхойлох; зохих бодлого, протоколуудыг боловсруулан гаргах.

Бизнесийн үйл ажиллагааны бүхий л чиглэлээр (судалгаа хийх, багшлах гэх мэт) олон улсын хамтын ажиллагааны шинэ боломжуудыг тодорхойлох.

Үйл ажиллагааны жишээ

- Өгөгдлийг аюулгүй бөгөөд найдвартай арга замаар хуваалцах зориулалттай системүүд болон журмууд нь байгууллагын хэмжээнд хамтран ажиллах үйл ажиллагааг дэмждэг байх
- Байгууллага доторх болон байгууллагын гаднах дижитал хамтын ажиллагааг үр дүнтэй, хүртээмжтэй явуулах дүрэм, удирдамж гаргахдаа оролцогч талуудтай хамтран ажиллах
- Систем, технологийг хуваалцах, болзошгүй сорилт, эрсдэлийг тодорхойлох зорилгоор үндэстэн дамнасан боловсролын түншүүдтэй хэрхэн хамтран ажиллах талаар авч үзэх





Олон нийтийн оролцоо

Өөрсдөд нь нөлөөлөх шийдвэр гаргах үйл явцад оролцоход нь оролцогч талуудад дэмжлэг үзүүлэх. Оролцогч талуудыг олон нийтийн үйл ажиллагаанд оролцох боломж олгох, дэмжих. Дижитал оролцоог тэгш, хүртээмжтэй байлгах нөхцөлөөр хангах.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Дижитал бүлэг үүсгэх | Дижитал оролцоо | Орон нутгийн иргэд | Бүс нутгийн өсөлт хөгжил | Харьяалагдах хэрэгцээ

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Дижитал хэрэгсэл ашиглан оролцогч талуудыг татан оролцуулах, тэдэнтэй зөвлөлдөх, үр дүнтэй шийдвэр гаргах замаар дижитал оролцоог байгууллага даяар дэмжих.

Орон нутгийн, үндэсний болон дэлхийн оролцогч талуудтай гадаад хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэн, дэмжих зорилгоор дижитал сүлжээ, нийгмийн сүлжээ, бусад хамтын ажиллагааны сувгуудыг хөгжүүлэн, нэвтрүүлэх.

Бүх оролцогч талуудад зориулж хүртээмжтэй байдал, тэгш оролцоо, тэгш боломжийг хангах үйлчилгээ, үйл ажиллагааг хөгжүүлэх.

Өөр өөр бүлгийн оролцогч талуудад нөлөөлж буй дижитал ядуурлын түвшинг үнэлж, шаардлагатай бол бууруулах арга хэмжээ авах.

Судалгаа хийж, судалгааны загварыг гарган төлөвлөж, хэрэглээнд нэвтрүүлдэг олон нийтийн, сайн дурын, арилжааны салбаруудтай хамтран ажиллах замаар суурь, хэрэглээний болон практикт суурилсан судалгааг мэдлэгийн солилцоо, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөлөл болгон хувиргах.

Үйл ажиллагааны жишээ

- Инноваци, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд орон нутгийн болон бүс нутгийн аж үйлдвэр, бизнесийн салбарт хувь нэмэр оруулах
- Ажилтнууд, оюутнуудынхаа мэдлэг, туршлагыг баяжуулж, нийгэм, байгаль орчны холбогдолтой эерэг өөрчлөлтийг дэмжих зорилгоор орон нутаг, бүс нутгийн соёл, нийгмийн санаачилгуудтай холбоо тогтоох



Харилцааны удирдлага

Харилцан хамтардаг түнш болох оролцогч талуудын хамтын ажиллагаа, санал хүсэлт, оролцоог нь хангах зорилгоор тэдэнтэй болоод тэдгээрийн хооронд эерэг харилцааг бий болгох, уг харилцааг хэвээр нь хадгалахад дижитал технологи ашиглах. Үүнд ажлын болон сургалтын харилцаа, өргөн хүрээндээ олон нийтийн харилцаа багтана.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Бизнес ба үйлдвэрлэл | Хэрэглэгчтэй харилцах харилцаа | Ажил олгогчтой харилцах харилцаа | Гадаад харилцаа | Хүний нөөц | Олон улсын үйл ажиллагаа | Орон нутгийн иргэд | Түншлэл | Оролцогч талуудын оролцоо |

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Стратегийн зорилтуудын дагуу дотоод болон гадаад оролцогч талуудтай (жишээ нь, ажил олгогчид, орон нутгийн бизнес эрхлэгчид, судлаачид, суралцагчид, төгсөгчид) хамтран ажиллах тухай оруулж өгсөн харилцан уялдаа холбоо бүхий харилцааны менежментийн стратегийг боловсруулж, удирдан чиглүүлэх.

Хэрэглэгчидтэй харилцаа харилцааг үр дүнтэй удирдах явдлыг дэмжих систем болон үйлчилгээг хөгжүүлэх (жишээ нь, үнэний нэг эх сурвалж буюу өгөгдлийн төвлөрсөн нэг сантай байх, хуучин системийг нэгтгэн ашиглах).

Дижитал сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан бусад байгууллага, оролцогч талуудтай түншлэл үүсгэх, сургалтын үйл ажиллагаа явагдах байршлуудыг холбох, олон нийт/ бизнес эрхлэгчид/орон нутгийн оролцоог хангах, мөн байгууллагын алсын хараа, үнэт зүйл, үйл ажиллагааг сурталчлах.

Үйл ажиллагааны жишээ


- Оюутнуудад орон нутгийн, бүс нутгийн, үндэсний болон олон улсын ажил олгогчидтой харилцаа холбоо тогтоон, харилцах боломж олгож, дэмжих
- Төгсөгчидтэй удаан хугацааны, тогтвортой харилцаатай байж, харилцаагаа хадгалах





Дижитал болон бодит дэд бүтэц

Сүлжээ, систем, техник хангамж, програм хангамж, дижитал технологиор тоноглогдсон бодит орон зайд зохих хөрөнгө оруулалт хийх зэргээр холбогдох мэдлэг, туршлага, алсын хараан дээр суурилсан найдвартай, аюулгүй дэд бүтэц цогцлоож, үр дүнтэй удирдлагаар хангах, стандарт хэрэгжилтийг дагаж мөрдүүлэх.





Найдвартай дижитал дэд бүтэц

Байгууллагын үр ашигтай үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих зорилгоор технологи, тоног төхөөрөмжийн цогц, аюулгүй, найдвартай системийг төлөвлөж, хөрөнгө оруулалт хийж, хэвийн ажиллагааг хангах.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Чиг хандлага тодорхойлох | Олон улсын үйл ажиллагаа | Орон нутгийн / бүс нутгийн / үндэсний статистик мэдээ | Салбарын статистик мэдээ

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Технологи, дэд бүтцийн хөгжил, дэвшлээс хоцрохгүй байх; шинээр гарсан хөгжил, дэвшлийг байгууллагын стратегийн тэргүүлэх чиглэл, үр ашигтай байдал, боломж, эрсдэлийн үүднээс үнэлэх.

Дэвшилтэт дижитал туршлагыг дэмжин нэвтрүүлэх, ирээдүйн хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад бэлэн байх зорилгоор дижитал шийдлүүдийг үнэлэх, төлөвлөх, худалдан авах ба / буюу хөгжүүлэх.

Стратеги, төлөвлөлтийг суурь мэдээллээр хангаж, чиглүүлэх зорилгоор байгууллагын бүх салбар, чиглэл дэх дижитал төлөвшлийн түвшинг үнэлэх.

Үйл ажиллагааны жишээ

- Бүх оролцогч талын бүлгүүдэд оролцож, хувь нэмрээ оруулах боломж олгох зорилгоор чиг хандлага тодорхойлох (horizon scanning) үйл ажиллагаануудыг бий болгох
- Үнэлгээ хийх алба, хэлтэс, нэгж дундын болон байгууллагыг хамарсан төлөвлөгөө, арга, журам боловсруулахыг дэмжих

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Байгууллагын стратеги | Дижитал манлайлал | Дижитал стратеги | Засаглал | МТ стратеги | Оролцогч талуудын оролцоо

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Байгууллагын тэргүүлэх чиглэл, үнэт зүйлсийг тусгасан, урьдчилан тооцоолоогүй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ашиглаж болох, уялдаа холбоо бүхий, уян хатан дижитал стратегийг боловсруулж, удирдан чиглүүлэх.

Дижитал стратегид тодорхой томъёолон тусгах нийтлэг алсын харааг тодорхойлоход бүх оролцогч талуудыг татан оролцуулах.

Удирдах ажилтнуудын санал, зөвлөмжийг дижитал стратегид тусгахад анхаарах, мөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд дижитал инновацын бизнесийн янз бүрийн үйл ажиллагаанд (жишээ нь, суралцах, заах, үнэлэх үйл явц, судалгаа шинжилгээ, бизнесийн үйл ажиллагаа, хүний нөөц, аюулгүй байдал) үзүүлэх нөлөөллийг ойлгодог гишүүдийг оруулах.

Үйл ажиллагааны жишээ

- Дижитал стратегийг үргэлжлүүлэн мэдээллээр хангаж, чиглүүлж байхын тулд өгөгдлийн урсгал, ажлын урсгал, үйл явцуудыг байгууллагын үйл ажиллагааны чиглэлүүдээр тулган харьцуулж тогтмол аудит хийн, хянаж байх.
 - Дижитал төлөвлөлтийг бусад холбогдох төлөвлөгөө, стратегитай (жишээ нь, олон улсын, эд хөрөнгө, суралцах, заах, үнэлэх үйл явц, оюутны туршлага, судалгаа, мэдээлэл, харилцаа холбоо, мэдээллийн технологи, корпорацийн төлөвлөгөө зэрэгтэй холбоотой) уялдуулж байх
 - Дижитал стратеги, төлөвлөгөөг үр дүнтэй, ахицтай хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын өөр өөр алба, хэлтэс, нэгжүүдийн төлөөллөөс бүрдсэн удирдах бүлгийг байгуулах
- Дижитал манлайлал, үр дүнтэй засаглалаар дамжуулан стратегийн дижитал алсын харааг
- хэрэгцээ, шаардлагадаа нийцүүлэн хэрэгжүүлэх (жишээ нь: нэгдүгээрт үүлэн технологи, нэгдүгээрт хөдөлгөөнт технологи, нэгдүгээрт дижитал технологи, нэгдүгээрт хүн, тогтвортой байдал)



Чиглэл / зарчим / үнэт зүйл

Хэрэглээний програмын архитектур | Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөлт | Бизнесийн үйл явц, үйл ажиллагаа | Дижитал манлайлал | Бизнесийн архитектур | Засаглал | Хөрөнгө оруулалт | Тогтвортой байдал

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Өөрчлөлт шилжилтийг авчрах дижитал технологи, өгөгдөл мэдээлэл, техник технологид стратегийн хөрөнгө оруулалт хийхдээ их сургуулийн удирдлагын дэмжлэгийг авах.

Байгууллага бизнесийн зорилгодоо хүрэх, оролцогч талуудын олон янзын хэрэгцээг хангах зорилгоор мэдээллийн технологийн систем, төхөөрөмж, платформ, үйлчилгээг худалдан авах ба/буюу хөгжүүлэх, хэрэгжүүлэх, удирдах, хэвийн ажиллагааг хангах боломжтой байхын тулд тогтвортой урт хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах.

Тухайн байгууллагын оруулсан хөрөнгийн өгөөжийг үр ашигтай байхаар тооцоолж шаардагдах нийт зардал, нөөцийг (капиталын болон үйл ажиллагааны зардал, хүний нөөц, сургалт гэх мэт) хөрөнгө оруулалтад тусгаж өгөх.

Үр ашиг, үр дүнг дээшлүүлж, бизнесийн үйл ажиллагааг оновчтой болгохын тулд систем, процессуудыг хянах, шаардлагатай бол стандартчилах.

Үйл ажиллагааны жишээ

- Одоо байгаа/хуучин систем, үйлчилгээг 1) шинэчлэх, төвлөрүүлэх ба/буюу үйл ажиллагааг нэгтгэх, 2) мөн түүнчлэн шаардлагатай бол шинийг хөгжүүлэх гэсэн хоёр чиглэлээр хөрөнгө оруулалт болон хүний нөөцийн үйл ажиллагааны тэнцвэрийг хангах
- Дийлэнх нь капитал зардлаас дийлэнх нь үйл ажиллагааны зардал руу шилжихдээ (жишээ нь, тодорхой хугацаагаар захиалан ашигладаг үүлэн үйлчилгээ рүү шилжих) хөрөнгө оруулалт, худалдан авалтад орох өөрчлөлтийг төлөвлөх
- Суурин тооцоолох төхөөрөмж болон хувийн төхөөрөмжөө ашиглахад зориулсан нөөц хэрэгсэл / байгууламж, дэд бүтэц (жишээ нь, өөрийн компьютер, төхөөрөмжөө авчрах эсвэл түрээслэн ашиглах бодлогын дагуу) гэсэн хоёр сонголтын дунд тэнцвэртэй хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөх
- Үр ашиг, хүртээмжийг аль болох хангалттай байх хэмжээнд байгууллагын өөр өөр алба, хэлтэс, нэгжүүдийн програм хангамжийн худалдан авалт, лиценз, хандах эрхийг нэгдсэн зохион байгуулалттайгаар зохицуулах
- Дижитал тоног төхөөрөмж, нөөцийн асуудлаар гадны хөрөнгө оруулалт авах боломжийг тодорхойлохын тулд түншүүдтэй хамтран ажиллах



Чиглэл / зарчим / үнэт зүйл

Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Дижитал ядуурал | Байгаль орчны тогтвортой байдал | Шаардлага тодорхойлох

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Өөр өөр бүлгийн оролцогч талуудын технологийн хэрэгцээг тодорхойлж, ойлгох зорилгоор тэдэнтэй зөвлөж саналыг нь хүлээн авах, тэднийг оролцуулж санал солилцох аргууд хэрэглэх.

Бүх оролцогч талуудад зориулагдсан бодит орчинтой ижил стандарт бүхий, ижил мэдрэмж туршлага өгөх, аюулгүй, ил тод дижитал орчныг бий болгох.

Дижитал дэд бүтэцтэй холбоотой шийдвэрүүд нь тэгш хүртээмж, тэгш оролцоо, тогтвортой байдал, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг анхаарч авч үзэх байгууллагын өргөн хүрээний зорилгуудын шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтлах.

Үйл ажиллагааны жишээ

- Дижитал дэд бүтцийг төлөвлөх, үүнтэй холбоотой шийдвэр гаргахдаа ажилтнууд болон оюутнуудын, ялангуяа ядуурал, хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн эрүүл мэнд, оршин суугаа байршил, хэл яриа, бусад тэгш хүртээмжтэй холбоотой бэрхшээл зэргийн асуудлаас болж оролцоо нь хангагдахгүй болох эрсдэлтэй байгаа хүмүүсийн олон талын хэрэгцээг харгалзан үзэх.
- Дижитал дэд бүтэцтэй холбоотой шийдвэр, үйл ажиллагаанууд нь оролцох, ажиллах, суралцах үйл явцуудад саад тотгор учруулахгүй байхад анхаарах
- Дижитал дэд бүтэцтэй холбоотой төлөвлөлт, шийдвэрүүдийг байгууллагын байгаль орчны тогтвортой байдлын зорилтуудтай (жишээлбэл, эрчим хүчний хэрэглээ, нүүрстөрөгчийн ул мөр, цэвэр тэглэлт буюу хүлэмжийн хийн ялгарал шингээлтийн зөрүүг тэг болгох) харгалзуулан авч үзэх
- Виртуал орчин нь бодит ертөнцийн олон янз байдлыг тусган, төлөөлж чадаж буй эсэхийг нягтлах.
- Бүх оролцогч талуудад дижитал орчны дизайнд идэвхтэй оролцох боломж олгох





Дижитал холболт

Байгууллага доторх оролцогч талууд, бизнесийн үйл явцууд, өгөгдөл, сүлжээнүүдийн хооронд аюулгүй, найдвартай холболтоор хангах, түүнчлэн зохих гадаад сүлжээнүүдтэй холбогдох боломжийг бүрдүүлэх.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөлт | Дижитал бүлэг үүсгэх | Кибер аюулгүй байдал | Дижитал ядуурал | Дижитал сүлжээ | Аюулгүй байдал, бизнесийн тасралтгүй байдал

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Онлайн үйлчилгээний одоогийн болон ирээдүйн төсөөлж буй эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хангалттай хүчин чадалтай байх зорилгоор өндөр боломжит зурвасын өргөн, үндсэн болон тэсвэрлэх чадвар өндөртэй сүлжээний холболтуудыг бий болгож, хэвийн ажиллагааг хангах. Мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг ханган, ажилтнууд болон оюутнуудыг сургуулийн орчин болон гадны ямар ч байршлаас систем, үйлчилгээ, контентод аюулгүй, найдвартай нэвтрэх боломж олгох.

Кибер аюулгүй байдлын хамгаалалт, магадлан итгэмжлэл, дэмжлэг үйлчилгээ, протоколуудын талаар сайтар ойлголттой болж, эдгээрийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах.

Өөр өөр бүлгийн оролцогч талуудын сүлжээнд холбогдох хэрэгцээг тодорхойлж, ойлгох зорилгоор тэдэнтэй зөвлөж саналыг нь хүлээн авах, тэднийг оролцуулж санал солилцох аргууд хэрэглэх.

Байгууллагын дижитал сүлжээнд нэвтрэх хандалт нь зөвхөн аюулгүй байгаад зогсохгүй ажилтнууд болон оюутнуудын, ялангуяа ядуурал, хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн эрүүл мэнд, оршин суугаа байршил, хэл яриа болон бусад тэгш хүртээмжтэй холбоотой бэрхшээл зэргийн асуудлаас болж оролцоо нь хангагдахгүй болох эрсдэлтэй байгаа хүмүүсийн олон талын хэрэгцээг хангаж байгаа эсэхэд анхаарах.

Оюутнуудыг эрүүл мэнд, сайн сайхан байдал, харьяалах хэрэгцээ, бусадтай харилцах харилцаагаа сайжруулахыг нь дэмжих, их сургуулийн хотхон дотроос болон гаднаас холбогдох боломж олгох олон төрлийн сонголтууд бүхий нэгдсэн арга хэрэгсэл, платформоор хангах.

Кибер аюулгүй байдлын чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнийг ажилд авах, хөгжүүлэх, ажлын байранд нь үлдээх боломжоор хангах. Сургалт, дэмжлэг үзүүлэх замаар одоо байгаа ажилтнуудын кибер аюулгүй байдлын мэдлэг, туршлагыг дээшлүүлэх хөтөлбөрт хөрөнгө оруулах.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Кибер аюулгүй байдал | Бизнесийн архитектур | Аюулгүй байдал, бизнесийн тасралтгүй байдал

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Дижитал дэд бүтэцтэй холбоотой төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шийдвэрүүд нь аюулгүй, тууштай, найдвартай бизнесийн үйл явцыг дэмжсэн байх шаардлагатай.

Системүүдийн ашиглалтын бэлэн байдлыг өндөр түвшинд хангах, их сургуулийн үйл ажиллагааг тасалдалгүйгээр үргэлжлүүлэхийн тулд бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөөг боловсруулах, турших, боловсронгуй болгон сайжруулах.

Үйл ажиллагааны жишээ

- Аюулгүй найдвартай систем, үйлчилгээ, контентоор хангах, хэвийн ажиллагааг хангах (жишээ нь, кибер аюулгүй байдлын хамгаалалт ба протоколууд)
- Тогтсон бизнесийн үйл ажиллагаанд хамгийн бага саад учруулах нөхцөлийг хангахын тулд шинэ систем, платформ, програмуудыг хэрэгжүүлэх ба / буюу нэгтгэхэд нэмэлт төлөвлөгөө гаргаж, зорилтот түвшин тогтоож, үе шаттай төлөвлөлт буюу замын зураглал хийх.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Өгөгдлийн архитектур | Өгөгдөл үүсгэх, удирдах | Өгөгдлийн нууцлал

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Санхүү болон цалин хөлс, хүний нөөц, маркетинг болон оюутны элсэлт, ахиц дэвшил, оюутны туршлага зэрэг үйл ажиллагааны чиглэл бүхий, дижитал технологид суурилсан, үр ашигтай байгууллагад өгөгдөлд тулгуурласан аргачлалыг нэвтрүүлэх.

Үйл ажиллагааны жишээ

- Өндөр чанартай, аюулгүй өгөгдлийг (жишээ нь бизнесийн оюуны архитектур, мэдээллийн төв, мэдээллийн хяналтын самбар, өндөр гүйцэтгэлтэй тооцоолол, өгөгдлийн дүрслэл) үр дүнтэй, ёс зүйтэй цуглуулж, ашиглах боломж олгох систем, үйлчилгээг хөгжүүлж, журам боловсруулан, дэмжих



Үйл ажиллагааны жишээ

- Дижитал холболтын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн талаар байгууллагаас удирдамж гаргах; дадал хэвшил, арга барилыг өөрчлөх замаар үүнийг багасгах аргуудыг санал болгох (жишээ нь, имэйл илгээх, хадгалахтай холбоотой нүүрстөрөгчийн ул мөр)
- Сүлжээ ашиглалт, сүлжээний үзүүлэлт, хүчин чадлыг тасралтгүй тандан хянаж, одоогийн болон ирээдүйд тулгарч буй сорилтуудыг (жишээ нь, цахим спорт, цахим шинжлэх ухаан) тодорхойлон гаргаж ирэх
- Байгууллагаар дамжуулан ханган нийлүүлсэн вэб сайт, дижитал үйлчилгээ, программууд руу олон өөр платформ / төхөөрөмж дээрээс нэвтрэн ашиглах боломжтой, эдгээрийг мөн тэгш хүртээмжийн (accessibility) стандарт, дүрэм журамд нийцүүлсэн байх шаардлагатай
- Хэрэглээнээс гарсан, хоцрогдсон, хамгаалалт муутай үйлчилгээ, системд хандсанаас болж хэн ч хохирохгүй байхад хатуу анхаарах
- Дэлхий дахины харилцан холбогдсон байдал, техникийн шалтгаант нөлөөллийн үр дагавар болон болзошгүй хязгаарлалтууд гэсэн сорилт, хүндрэлүүдийг тооцож үзэх
- Өгөгдлийн нууцлал, ёс зүй, мөн гэрээсээ ажиллах орчин нөхцөлд үүсэх кибер аюулгүй байдлын асуудлуудад анхаарсан зохих төлөвлөгөө, бодлогыг боловсруулах
- Олон давхар баталгаажуулалт, нууц үг зохицуулах хэрэгслүүд, аюул заналыг илрүүлэх, тандан хяналт буюу мониторинг, ransomware буюу өгөгдөл барьцаалах халдлагаас хамгаалах программ хангамж, төгсгөлийн цэг буюу төгсгөлийн хэрэглэгчийн төхөөрөмж болох суурин болон зөөврийн компьютер, гар утас гэх мэтийн аюулгүй байдал, wifi утасгүй сүлжээний аюулгүй байдал зэрэг дижитал аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг өргөжүүлэх, сайжруулах, шинээр нэвтрүүлэх.
- Мэдээллийн аюулгүй байдлыг удирдан зохицуулахын тулд ISO 270001 гэрчилгээтэй болох зорилт тавьж ажиллах
- Халдлагын нөлөөллийг бууруулахын тулд ослын хариу арга хэмжээ авах, шүүх шинжилгээ хийх, байгууллагын дижитал эд хөрөнгийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн үйлчилгээтэй хамтран ажиллаж, тэдгээрт хандах боломжтой
- Кибер аюулгүй байдлыг хангах зохих үйлчилгээнд (жишээ нь Cyber Essentials) хандах, аюул заналын талаар мэдээлэл хуваалцах арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцох



Дижитал дэмжлэг

Оролцогч талуудад дижитал технологийг ажил, хичээл, судалгаа шинжилгээндээ үр дүнтэй ашиглахад нь туслах зорилгоор олгох нөөц, үйлчилгээ, тусламж.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

[Дижитал манлайлагчид](#) | [Дижитал чадавх](#) | [Дижитал сургалтын манлайлагчид](#) | [Сургалтын технологич](#) | [Ажилтанд үзүүлэх дэмжлэг](#) | [Оюутанд үзүүлэх дэмжлэг](#)

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг төвлөрсөн үйлчилгээний албанд, мөн дижитал мэргэжилтний ур чадвар шаардагдах бусад албан тушаалд ажиллуулахаар авах, хөгжүүлэх, ажлын байранд нь тогтвортой ажиллуулах боломж нөхцөлөөр хангах.

Мэдээллийн технологийн дэмжлэг үзүүлэх багийг хөгжүүлэх, удирдах, мэдээллийн технологийн сургалтын нөөцийг хөгжүүлэх ба/буюу худалдан авах; багшаар удирдуулсан биечилсэн сургалт болон хэрэгцээтэй үедээ ашиглах боломжтой сургалтын материал / нөөц хоорондын тэнцвэрийг хангах, байгууллагын систем болон үүлэнд суурилсан үйлчилгээг дэмжих, хувийн төхөөрөмж болон үйлчилгээг / програм хангамжийг дэмжих. Олон төрлийн синхрон / шууд ба асинхрон / шууд бус алсын зайн тусламж үйлчилгээ үзүүлэх.

Үйл ажиллагааны жишээ

- Шинэ дижитал системүүд болон томоохон шинэчлэлтүүдийг нэвтрүүлэх, сургах ажлыг удирдах
- Мэдээллийн технологийн дэмжлэг үйлчилгээ ба янз бүрийн дижитал хэрэглээг (жишээлбэл, дижитал сургалт, дижитал судалгаа, өгөгдлийн аналитик) дэмжих хоёрын ялгааны талаар нийтлэг ойлголтыг бий болгох





Эд хөрөнгийн удирдлага

Санхүүгийн болон байгаль орчны хувьд тогтвортой, зориулалтын барилга байгууламж бүхий бодит хөрөнгийг төлөвлөх, хөгжүүлэх, удирдах, хэвийн байдлыг хангах. Стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд биет болон виртуал дэд бүтцийг үр ашигтай, үр дүнтэй нэгтгэх шаардлагатай.

Чиглэл / зарчим / үнэт зүйл

Дижитал стратеги | Байгаль орчны тогтвортой байдал | Эд хөрөнгийн стратеги | Ухаалаг хотхон буюу кампус | МТ стратеги | Сургалтын орчин | Сургалтын орон зай | Номын сан, сургалтын нөөц хэрэгсэл | Суралцах орон зай

Үйл ажиллагааны хамрах хүрээ

Виртуал болон бодит дэд бүтцийг нэгтгэсэн эд хөрөнгийн стратегийг төлөвлөх. Шийдвэр гаргахад тустай хөрөнгө ашиглалтын өгөгдлийг үүсгэдэг сүлжээнд холбогдсон төхөөрөмжүүд, мэдрэгчүүд бүхий ухаалаг орчны тухай ойлголтыг эд хөрөнгийн стратеги, төлөвлөгөөнд тусгасан байх ёстой.

Өөр өөр нийгмийн бүлгийн дижитал хэрэглэгчдийг шинэ барилга, засварын ажил төлөвлөхөд оролцуулж, хэрэгцээ шаардлагыг тусгах.

Олон талаар ашиглаж болох янз бүрийн бодит орон зай, тоног төхөөрөмжүүд руу биетээр болон зайнаас нэвтрэх, тэдгээрийг үр дүнтэй ашиглахад дэмжлэг үзүүлэх системүүдийг боловсруулж, удирдах.

Үйл ажиллагааны жишээ

- Сургалтын өрөөнүүд, тэдгээрийн "зорилго" буюу нөхцөл байдлаас хамааруулан дахин тохируулах боломж (жишээ нь, гэрлийг бүдгэрүүлэх, тодруулах, тавилгыг өөрчлөх), доторх тоног төхөөрөмж, түүний дотор тусгай тоног төхөөрөмж бүхий өрөөнүүдэд бүрэн аудит хийх
- Байгууллага даяар системүүдийг боловсронгуй болгож, өрөө болон тоног төхөөрөмжийн урьдчилсан захиалгыг хялбарчлах, өрөө ашиглалтыг хянан тооцоолж, бодит орон зайг дутуу, хэтрүүлэн, үр ашиггүй ашиглаж байгаа эсэхийг нягтлах
- Тасралтгүй сайжруулалт, хөгжлийг дэмжих зорилгоор их сургуулийн хотхоны зай, талбай ашиглалт болон замын хөдөлгөөнийг тодорхойлохын тулд ухаалаг орчны өгөгдлийг ашиглах
- Биечлэн ирэх буюу бодит орон зайд нэвтрэх боломжгүй байгаа хүмүүст зориулж виртуал аялалын үйлчилгээ үзүүлэх
- Урьдчилан захиалах боломжтой хосолсон болон виртуал орон зайнууд бий болгох
- Багшлах боловсон хүчний дижитал чадавхыг хөгжүүлэх төлөвлөгөөнд сургалтын орон зай, тоног төхөөрөмжийг сургалтын үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглах талаар тусган оруулж, сургалтын орон зайг ашиглах талаар ажилтнууд болон оюутнуудад дэмжлэг үзүүлж, сургалтын материалаар хангах
- Сургалтын янз бүрийн орон зайд тавилга, өрөөний зохион байгуулалт, технологийн хэрэглээ, сургалтын арга барилыг анхаарч тооцон, сургалтын хэрэгцээндээ тааруулан тохируулж болох уян хатан сонголтуудаар хангах. Холимог / хосолсон нөхцөлд заах, сурахад нөлөөлж болох хязгаарлалтуудыг авч үзэх
- Технологиор тоногдсон олон тооны өрөөнүүдийг зохих ёсоор хэвийн байдалтай / ажиллагаатай (мөн сүүлийн үеийн шинэчлэлээс хоцроолгүй) байлгахад шаардагдах техникийн дэмжлэг үйлчилгээний түвшинг үнэлэх. Техникийн, захиргааны болон сургалтын хосолсон дэмжлэг үйлчилгээ хангалттай бөгөөд зохистой түвшинд байгаа эсэхэд анхаарах



Бусад сурвалж, индекс

Бусад эх сурвалж

Уг тогтолцоонд дараах сурвалжуудаас холбогдох мэдээллийг авч, ашигласан болно:

Хмсх-с хэвлэн, нийтлүүлсэн

- Beetham, H. and MacNeill, S. (2022). Approaches to curriculum and learning design across UK higher education. Bristol: Jisc. Дараах холбоосоор хандана уу: <https://beta.jisc.ac.uk/reports/approaches-to-curriculum-and-learning-design-across-uk-higher-education>
- losad, A (2020). Digital at the core: a 2030 strategy framework for university leaders. London: Emerge Education; and Bristol: Jisc. Дараах холбоосоор хандана уу: jisc.ac.uk/guides/digital-strategy-framework-for-university-leaders
- Jisc (2018). Developing digital capability: an organisational framework. Bristol: Jisc. Дараах холбоосоор хандана уу: https://repository.jisc.ac.uk/6610/1/JFL0066F_DIGICAP_MOD_ORG_FRAME.PDF
- Pauli, M. (2021). Rethinking assessment. Bristol: Jisc. Дараах холбоосоор хандана уу: <https://beta.jisc.ac.uk/reports/rethinking-assessment>
- Skelton, N. (2023). Digital strategies in UK higher education: making digital mainstream. Bristol: Jisc. Дараах холбоосоор хандана уу: <https://beta.jisc.ac.uk/reports/digital-strategies-in-uk-higher-education-making-digital-mainstream>

Хмсх-с гаргасан програм, хэрэгсэл

- Jisc. Digital leaders programme. Дараах холбоосоор хандана уу: <https://www.jisc.ac.uk/training/digital-leaders-programme>
- Jisc. Digital elevation tool. Дараах холбоосоор хандана уу: <https://beta.jisc.ac.uk/digital-elevation-tool>

Дижитал шилжилтийн загвар, тогтолцоо

- Brooks, D C and McCormack, M (2020). Driving digital transformation in higher education. Boulder, CO: EDUCAUSE. Дараах холбоосоор хандана уу: edUCAUSE.edu/ecar/research-publications/driving-digital-transformation-in-higher-education/2020/introduction-and-key-findings [accessed September 2022].
- Deloitte. Digital transformation. Дараах холбоосоор хандана уу: deloitte.com/global/en/our-thinking/insights/topics/digital-transformation.html
- EAB (2021). Digital transformation: foundational capabilities and high-impact investments to keep your campus relevant in a digital era. Washington DC: EAB. Дараах холбоосоор хандана уу: <https://eab.com/wp-content/uploads/2021/05/PDF-ITF-Digital-Transformation-Brief.pdf>

- EDUCAUSE (2022). Digital transformation is the future of higher education. Boulder, CO: EDUCAUSE. Дараах холбоосоор хандана уу: <https://dx.educause.edu>
- Microsoft. Digital transformation, accelerated. Дараах холбоосоор хандана уу: microsoft.com/en-gb/industry/digital-transformation
- MIT. 5 building blocks of digital transformation. Дараах холбоосоор хандана уу: <https://mitsloan.mit.edu/ideas-made-to-matter/5-building-blocks-digital-transformation>
- UCISA Enterprise Architecture Group (2022). The Higher Education Reference Models (HERM). Дараах холбоосоор хандана уу : ucisa.ac.uk/Groups/Enterprise-Architecture-Group/HERM

Мэдлэгийн практик дадал

Bassett, R.M. (2021). “From University to Multiversity to Omniversity: HEIs as Hubs for Dynamic Development”. In: van’t Land, H., Corcoran, A., Iancu, DC. (eds) The Promise of Higher Education. Springer, Cham. Дараах холбоосоор хандана уу: https://doi.org/10.1007/978-3-030-67245-4_59

Goetze, T. “The concept of a university: theory, practice, and society.” Danish Yearbook of Philosophy, 52 (1). pp. 61-81. ISSN 0070-2749 Дараах холбоосоор хандана уу: <https://doi.org/10.1163/24689300-05201001>

Karlgren, K.; Paavola, S. and Ligorio, M.B. (2020) “Introduction: what are knowledge work practices in education? How can we study and promote them?”. Research Papers in Education, 35:1, 1-7, DOI: 10.1080/02671522.2019.1677761

Kerr, C. (1963). “The Uses of the University”. Harvard University Press.

Leonard, D. and Barton, M. (2013) “Knowledge and the management of creativity and innovation”, in Dodgson, M.; Gann, D.M. and Phillips, N. (eds). The Oxford Handbook of Innovation Management (2014; online edn, Oxford Academic, 16 Dec. 2013), Дараах холбоосоор хандана уу: <https://doi.org/10.1093/oxfordhb/9780199694945.013.005>

Merx-Chermin, M. and Nijhof, W. J. (2005). “Factors influencing knowledge creation and innovation in an organisation”. Journal of European Industrial Training, 29(2), 135–147. Дараах холбоосоор хандана уу: <https://doi.org/10.1108/03090590510585091>

O Riordan, N. (2013). “Knowledge creation: Hidden driver of innovation in the digital Era.” International Conference on Information Systems (ICIS 2013): Reshaping Society Through Information Systems Design. 3.

Rodríguez-Abitia, G. and Bribiesca-Correa, G. “Assessing Digital Transformation in Universities.” Future Internet 2021, 13, 52. Дараах холбоосоор хандана уу: <https://doi.org/10.3390/fi13020052>

Индекс

Тэгш хүртээмж, тэгш оролцоо

- Дижитал соёл ба сэтгэлгээ
- Байгууллагын сайн сайхан байдал
- Дижитал технологи ашиглан суралцах
- Суралцагчийн туршлага
- Хамтын ажиллагаа
- Харилцаа холбоо
- Олон нийтийн оролцоо
- Найдвартай дэд бүтэц
- Дижитал холболт

Программын архитектур

- Найдвартай дижитал дэд бүтэц

Үнэлэх, дүгнэх

- Хичээлийн хөтөлбөр боловсруулах
- Дижитал технологи ашиглан заах

Суурь түвшин тогтоох

- Бизнесийн оюун
- Байгууллагын өөрчлөлт

Жишиг тогтоох

- Дижитал алсын хараа, чиг хандлага
- Бизнесийн оюун

Бизнесийн оюунд тулгуурласан стратеги

- Бизнесийн оюун / BI

Дижитал бүлэг үүсгэх

- Байгууллагын дүр төрх
- Судалгаа
- Өргөн хүрээний нөлөөлөл
- Суралцагчийн туршлага
- Олон нийтийн оролцоо
- Дижитал холболт

Бизнес болон аж үйлдвэр

- Байгууллагын дүр төрх
- Харилцааны удирдлага

Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөлт

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Бизнесийн оюун
- Найдвартай дижитал дэд бүтэц
- Дижитал холболт

Бизнесийн үйл явц, үйл ажиллагаа

- Найдвартай дижитал дэд бүтэц
- Өгөгдлийн удирдлага ба хэрэглээ

Дижитал цуглуулгын удирдлага

- Мэдээллийн удирдлага, хэрэглээ

Олон нийтийн хамтын ажиллагаа

- Хамтын ажиллагаа
- Инновац

Нийцэл

●Өгөгдлийн удирдлага, хэрэглээ

Байгууллагын стратеги

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Байгууллагын өөрчлөлт
- Найдвартай дижитал дэд бүтэц

Сургалтын хөтөлбөрийн дизайн

● Сургалтын хөтөлбөр боловсруулах

Сургалтын хөтөлбөрийн тогтолцоо

● Сургалтын хөтөлбөр боловсруулах

Хэрэглэгчтэй харилцах харилцаа

● Харилцааны удирдлага

Кибер аюулгүй байдал

- Байгууллагын сайн сайхан байдал
- Өгөгдлийн удирдлага, хэрэглээ
- Найдвартай дижитал дэд бүтэц
- Дижитал холболт

Өгөгдлийн аналитик

- Өгөгдлийн удирдлага, хэрэглээ
- Дижитал технологи ашиглан заах

Өгөгдлийн архитектур

- Өгөгдлийн удирдлага, хэрэглээ
- Найдвартай дижитал дэд бүтэц

Өгөгдөл үүсгэх, удирдах

- Найдвартай дижитал дэд бүтэц

Өгөгдлийн ёс зүй

● Өгөгдлийн удирдлага, хэрэглээ

Өгөгдлийн боловсрол

● Өгөгдлийн удирдлага, хэрэглээ

Өгөгдлийн нууцлал

- Өгөгдлийн удирдлага, хэрэглээ
- Найдвартай дижитал дэд бүтэц

Өгөгдлийн чанар

● Өгөгдлийн удирдлага, хэрэглээ

Өгөгдлийн стратеги

● Өгөгдлийн удирдлага, хэрэглээ

Дижитал чадавх

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Сургалтын хөтөлбөр боловсруулах
- Дижитал технологи ашиглан суралцах
- Дижитал технологи ашиглан заах
- Дижитал дэмжлэг үйлчилгээ

Дижитал манлайлагчид

- Дижитал дэмжлэг үйлчилгээ

Дижитал хамтын ажиллагаа

● Хамтын ажиллагаа

Дижитал харилцаа холбоо

● Хамтын ажиллагаа

Дижитал итгэлийн түвшин

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Шийдвэр гаргах

Дижитал бүтээлч байдал

- Дижитал алсын хараа, чиг хандлага
- Инновац

Дижитал ёс суртахуун

● Харилцаа холбоо

Дижитал нотолгоо буюу өгөгдөл

● Шийдвэр гаргах

Дижитал цогц чадвар

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Байгууллагын сайн сайхан байдал
- Суралцагчийн туршлага
- Шийдвэр гаргах

Дижитал мэдээлэл

● Мэдээллийн удирдлага, хэрэглээ

Дижитал инновац

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Байгууллагын өөрчлөлт

Дижитал манлайлал

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Байгууллагын өөрчлөлт
- Дижитал алсын хараа, чиг хандлага
- Инновац
- Бизнесийн оюун
- Шийдвэр гаргах
- Найдвартай дижитал дэд бүтэц

Дижитал сургалтын манлайлагчид

● Дижитал дэмжлэг

Дижитал мэдээллийн хэрэгсэл

- Харилцаа холбоо
- Мэдээллийн удирдлага, хэрэглээ

Дижитал сүлжээ

- Харилцаа холбоо
- Дижитал холболт

Дижитал оролцоо

- Олон нийтийн оролцоо
- Суралцагчийн туршлага

Дижитал ядуурал

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Дижитал технологи ашиглан суралцах
- Найдвартай дижитал дэд бүтэц
- Дижитал холболт

Дижитал хадгалалт

Мэдээллийн удирдлага, хэрэглээ

Дижитал стратеги

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Байгууллагын өөрчлөлт
- Судалгаа
- Инновац
- Сургалтын хөтөлбөр боловсруулах
- Бизнесийн оюун
- Найдвартай дижитал дэд бүтэц
- Эд хөрөнгийн удирдлага

Дижитал алсын хараа

- Дижитал алсын хараа, чиг хандлага
- Шийдвэр гаргах

Дижитал сайн сайхан байдал

- Байгууллагын өөрчлөлт
- Суралцагчийн туршлага

Э-портфолио

- Дижитал технологи ашиглан суралцах

Эдийн засгийн/санхүүгийн боловсрол

- Байгууллагын сайн сайхан байдал

Үр бүтээмжтэй дижитал суралцагчид

- Дижитал технологи ашиглан суралцах

Хөдөлмөрийн харилцаа

- Байгууллагын сайн сайхан байдал
- Харилцааны удирдлага

Бизнесийн архитектур

- Өгөгдлийн удирдлага, хэрэглээ
- Найдвартай дижитал дэд бүтэц

Байгаль орчны тогтвортой байдал

- Байгууллагын сайн сайхан байдал
- Найдвартай дижитал дэд бүтэц
- Эд хөрөнгийн удирдлага

Эд хөрөнгийн стратеги

- Эд хөрөнгийн удирдлага

Ёс зүйт систем, процесс

- Бизнесийн оюун

Ёс зүй

- Судалгаа
- Мэдээллийн удирдлага, хэрэглээ

Гадаад харилцаа

- Өргөн хүрээний нөлөөлөл
- Харилцааны удирдлага

Уян хатан сургалт

- Дижитал технологи ашиглан суралцах

Уян хатан ажлын байр

- Байгууллагын сайн сайхан байдал
- Дижитал технологи ашиглан суралцах

Урьдчилсан таамаглал

- Бизнесийн оюун

Урьдчилан харах

- Байгууллагын өөрчлөлт
- Дижитал алсын хараа, чиг хандлага

Ирээдүйн хувилбарт таамаг

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Дижитал алсын хараа, чиг хандлага

Засаглал

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Огноогийн удирдлага, хэрэглээ
- Найдвартай дижитал дэд бүтэц

Чиг хандлага тодорхойлох

- Дижитал алсын хараа, чиг хандлага
- Бизнесийн оюун
- Найдвартай дижитал дэд бүтэц

Хүний нөөц

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Байгууллагын сайн сайхан байдал
- Харилцааны удирдлага

Аж үйлдвэрлэлийн чиг хандлага

- Дижитал алсын хараа, чиг хандлага

Мэдээллийн боловсрол

- Мэдээллийн удирдлага, хэрэглээ

Мэдээлэл хадгалах, татан ашиглах

- Мэдээллийн удирдлага, хэрэглээ

Мэдээллийн стратеги

- Мэдээллийн удирдлага, хэрэглээ

Ухаалаг кампус / их сургуулийн хотхон

- Эд хөрөнгийн удирдлага

Олон улсын үйл ажиллагаа

- Огноогийн удирдлага, хэрэглээ
- Дижитал алсын хараа, чиг хандлага
- Судалгаа
- Өргөн хүрээний нөлөөлөл
- Сургалтын хөтөлбөр боловсруулах
- Суралцагчийн туршлага
- Харилцааны удирдлага
- Найдвартай дижитал дэд бүтэц

Хөрөнгө оруулалт

- Огноогийн удирдлага, хэрэглээ
- Найдвартай дижитал дэд бүтэц

МТ стратеги

- Найдвартай дижитал дэд бүтэц
- Эд хөрөнгийн удирдлага

Суралцахуй

- Сургалт хөтөлбөр боловсруулах

Сургалтын дизайн

- Сургалтын хөтөлбөр боловсруулах

Сургалтын орчин

- Дижитал технологи ашиглан заах
- Эд хөрөнгийн удирдлага

Сургалтын материаллаг бааз

● Дижитал технологи ашиглан заах

Сургалтын хэлбэрүүд

● Сургалтын хөтөлбөр боловсруулах

Сургалтын нөөц

● Сургалтын хөтөлбөр боловсруулах

● Дижитал технологи ашиглан заах

Сургалтын орон зай

● Дижитал технологи ашиглан заах

● Эд хөрөнгийн удирдлага

Суралцах, заах, үнэлэх стратеги

● Сургалтын хөтөлбөр боловсруулах

Сургалтын технологич

● Дижитал технологи ашиглан заах

● Дижитал дэмжлэг

Номын сан, сургалтын нөөц

● Судалгаа

● Дижитал технологи ашиглан заах

● Дижитал технологи ашиглан заах

● Мэдээллийн удирдлага, хэрэглээ

● Эд хөрөнгийн удирдлага

Орон нутгийн иргэд

● Өргөн хүрээний нөлөөлөл

● Олон нийтийн оролцоо

● Харилцааны удирдлага

Орон нутгийн / бүс нутгийн / үндэсний статистик мэдээ

● Найдвартай дижитал дэд бүтэц

Орон нутгийн / бүс нутгийн / үндэсний нөлөөлөл

● Өргөн хүрээний нөлөөлөл

Удирдлагын мэдээлэл

● Мэдээллийн удирдлага ба хэрэглээ

● Бизнесийн оюун

Зах зээлийн мэдээлэл

● Бизнесийн оюун

Маркетинг, харилцаа холбоо

● Байгууллагын дүр төрх

● Өргөн хүрээний нөлөөлөл

● Харилцаа холбоо

Нээлттэй боловсролын туршлага

● Дижитал технологи ашиглан заах

Нээлттэй боловсролын нөөц

● Дижитал технологи ашиглан заах

Нээлттэй судалгаа

● Судалгаа

Нээлттэй хуваалцах

● Хамтын ажиллагаа

Нээлттэй, ил тод байдал

● Бизнесийн оюун

Үйл ажиллагааны өөрчлөлт

● Байгууллагын өөрчлөлт

Байгууллагын харилцаа холбоо

● Харилцаа холбоо

Байгууллагын үнэт зүйл

● Дижитал соёл болон сэтгэлгээ

Түншлэл

● Харилцааны удирдлага

Хувь хүнд чиглэсэн сургалт

● Дижитал технологи ашиглан суралцах

Асуудал шийдвэрлэх

● Шийдвэр гаргах

Бүс нутгийн өсөлт хөгжил

● Олон нийтийн оролцоо

Шаардлага тодорхойлох

● Найдвартай дижитал дэд бүтэц

Судалгааны хамтын ажиллагаа

● Судалгаа

Судалгааны удирдлага, дэмжлэг

● Судалгаа

Судалгааны ур чадвар дээшлүүлэх, сургалтанд хамрагдах

● Судалгаа

Судалгааны дэмжлэг

● Судалгаа

Салбарын мэдээлэл, тоо баримт

● Найдвартай дижитал дэд бүтэц

Салбарын чиг хандлага

● Дижитал алсын хараа, чиг хандлага

Аюулгүй байдал, бизнесийн тасралтгүй байдал

● Өгөгдлийн удирдлага болон хэрэглээ

● Найдвартай дижитал дэд бүтэц

● Дижитал холболт

Бие даан суралцах

● Дижитал технологи ашиглан суралцах

Харьяалагдах хэрэгцээ

● Байгууллагын дүр төрх

● Суралцагчийн туршлага

● Олон нийтийн оролцоо

Нийгмийн сүлжээ ашиглах

● Харилцаа холбоо

Ажилтнуудын хамтын ажиллагаа

● Хамтын ажиллагаа

Ажилтнуудын хөгжил

● Дижитал технологи ашиглан суралцах

● Дижитал технологи ашиглан заах

Ажилд авах, ажилд үлдээх

- Байгууллагын сайн сайхан байдал
- Дижитал технологи ашиглан суралцах

Ажилтанд үзүүлэх дэмжлэг

- Байгууллагын сайн сайхан байдал
- Дижитал дэмжлэг

Оролцогч талын оролцоо

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Харилцааны менежмент
- Найдвартай дижитал дэд бүтэц

Стратеги төлөвлөлт

- Дижитал алсын хараа, чиг хандлага

Оюутны сонголт

- Дижитал технологи ашиглан суралцах

Оюутны хамтын ажиллагаа

- Хамтын ажиллагаа

Оюутны туршлага

- Суралцагчийн туршлага

Оюутан суралцах

- Дижитал технологи ашиглан суралцах

Оюутны ахиц

- Дижитал технологи ашиглан суралцах

Оюутанд үзүүлэх дэмжлэг

- Дижитал технологи ашиглан суралцах
- Дижитал технологи ашиглан заах
- Суралцагчийн туршлага
- Дижитал дэмжлэг

Сурах орон зай

- Дижитал технологи ашиглан суралцах
- Мэдээллийн удирдлага, хэрэглээ
- Эд хөрөнгийн удирдлага

Тогтвортой байдал

- Найдвартай дижитал дэд бүтэц

Магадлах

- Сургалтын хөтөлбөр боловсруулах

Хмсх-ны харилцааны менежертэй [ji.sc/
contact-relationship-manager](https://ji.sc/contact-relationship-manager) холбоосоор
нэвтрэн холбогдоно уу – Бид та
бүхэнтэй энэхүү тайлантай холбоотой
ямар ч асуудлаар ярилцахад бэлэн
байна.

Jisc
4 Portwall
Lane, Bristol
BS1 6NB 0300
300 2212

help@jisc.ac.uk
[@Jisc](https://jisc.ac.uk)

Энэхүү баримт бичиг нь 2023
оны 2-р сард хэвлэгдсэн бөгөөд
CC BY-NC-SA лицензээр
хамгаалагдсан болно.

